

ТАНИЛЦУУЛГА ТОВХИМОЛ



Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагын

УДИРДАМЖ

ДЭМБ-ын Номын сангийн каталоги

Хамт Олонд Түшиглэн Сэргээн Засах Хандлага: ХОТСЗ хандлагын Удирдамж

1.Сэргээн засалт. 2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн. 3.Хамт олонд түшиглэсэн эрүүл мэндийн үйлчилгээ. 4.Эрүүл мэндийн бодлого. 5.Хүний эрх. 6.Нийгмийн шударга ёс. 7.Хэрэглэгчийн оролцоо. 8.Удирдамж. I.Дэлхийн эрүүл мэндийн байгууллага. II.НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Байгууллага. III.Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага. IV. Хөгжлийн бэрхшээл, Хөгжлийн олон улсын консорциум

ISBN 978 92 4154805 2

(NLM ангилал: WB 320)

© Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага 2010

Бүх эрх хадгалагдсан. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын хэвлэлийг WHO Press, World Health Organization, 20 Avenue, 1211 Geneva 27, Switzerland (tel: +41 22 791 3264; fax: +41 22 791 4857; e-mail: bookorder@who.int) -аас авч болно. ДЭМБ-ын хэвлэлийг орчуулах эсвэл дахин боловсруулж зарах эсвэл арилжааны бус байдлаар хэрэглэх алинд нь ч зөвшөөрөл авах ба ДЭМБ-ын Хэвлэлийн газарт дээр дурдсан хаягаар (fax: +41 22 791 4806; e-mail: permission@who.int) хандана.

Энэхүү хэвлэлийн дотоод агуулга нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын үзэл бодлыг илэрхийлэхгүй. Газрын зурган дээрх цэгэн зураас хилийг ойролцоогоор төлөөлсөн.


Үүнд дурдагдсан тухайн онцгойлсон компани эсвэл үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүн нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас зөвлөсөн эсвэл зөвшөөрсөн гэсэн үг биш.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага энэхүү хэвлэлд орж буй мэдээллийг баталгаажуулж бүх боломжит урьдчилан сэргийлэх аргуудыг авсан хэдий ч уг хэвлэлийг ямар нэгэн илэрхийлэл, зөвшөөрлийн баталгаагүйгээр тараасан болно. Орчуулгын хариуцлага болон уг материалыг ашиглах эрх нь уншигч танд буй. Үүнийг ашиглахад гарах ямар нэгэн хохирлыг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага хариуцахгүй.

Хэвлэлийн дизайн, загварыг Inis Communication

www.iniscommunication.com

Мальтад хэвлэв.



Энэхүү товхимлыг Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвшөөрөлтэйгөөр Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллагын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” төслийн санхүүжилтээр 600 хувь хэвлэв.

СЗСҮТ

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Эрхүүгийн гудамж, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв
20-р салбар, Ш,х: №364

Утас:352423

Цахим шуудан: info@nrc.gov.mn

Цахим хуудас: www.nrc.gov.mn

АИФО

Холбоо барих хаяг:

АИФО байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар

Улаанбаатар 210648, Ш,х:75

Утас: 70153058

Дэлхийн зөн

Холбоо барих хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, 15-р хороо, (133-70), Энхтайвны өргөн чөлөө, 49-р барилга, Соманг плаза, 4-р давхар, Улаанбаатар 15160,

Шуудангийн хайрцаг 705

Вэб: <http://www.wvi.org/mongolia>

- **“Танилцуулга” товхимол**

Орчуулсан: М.Энхдулам, СЗСҮТ-н мэргэжилтэн

Хянасан: Д.Тулгамаа, нийгмийн ухааны магистр, удирдахуйн ухааны докторант

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Жавхлан, СЗСҮТ-ийн Мэдээлэл технологийн мэргэжилтэн

- **“Эрүүл мэнд” бүрэлдэхүүн хэсэг**

Орчуулсан: Б.Түмэнжаргал, Дэлхийн Зөн Монгол ОУБ-ын “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн гэрэлт ирээдүй” төслийн ажилтан, докторант

Хянасан: Д. Тулгамаа, АИФО байгууллагын суурин төлөөлөгч, нийгмийн ухааны магистр, докторант

Г.Түвшинжаргал, СЗСҮТ-ийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

С.Баярбат, СЗСҮТ-ийн Бодлогын хэрэгжилт, нийгмийн оролцооны хэлтсийн дарга, хууль зүйн ухааны магистр

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Жавхлан, СЗСҮТ-ийн Мэдээлэл технологийн мэргэжилтэн

- **“Боловсрол” бүрэлдэхүүн хэсэг**

Орчуулсан: П.Чимэддулам, СЗСҮТ-н мэргэжилтэн

Хянасан: Г.Түвшинжаргал, СЗСҮТ-ийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Жавхлан, СЗСҮТ-ийн Мэдээлэл технологийн мэргэжилтэн

- **“Амьжиргаа” бүрэлдэхүүн хэсэг**

Орчуулсан: М.Энхдулам, СЗСҮТ-ийн мэргэжилтэн

Б.Цэвэлмаа, СЗСҮТ-ийн мэргэжилтэн

Хянасан: Д. Тулгамаа, АИФО байгууллагын суурин төлөөлөгч, нийгмийн ухааны магистр, докторант

С.Баярбат, СЗСҮТ-ийн Бодлогын хэрэгжилт, нийгмийн оролцооны хэлтсийн дарга, хууль зүйн ухааны магистр

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Жавхлан, СЗСҮТ-ийн Мэдээлэл технологийн мэргэжилтэн

- **“Нийгмийн” бүрэлдэхүүн хэсэг**

Орчуулсан: М.Намсрайхүү, НЗДТГ-ын мэргэжилтэн, нийгмийн ухааны магистр

Хянасан: Д.Тулгамаа, АИФО байгууллагын суурин төлөөлөгч, нийгмийн ухааны магистр, докторант

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Жавхлан, СЗСҮТ-ийн Мэдээлэл технологийн мэргэжилтэн

- **“Эрх мэдэлжүүлэх” бүрэлдэхүүн хэсэг**

Орчуулсан: Д.Тулгамаа, нийгмийн ухааны магистр, удирдахуйн ухааны докторант

Хянасан: А.Дамдинсүрэн, анагаах ухааны доктор

Л.Энхбуянт, нийгмийн ухааны магистр, удирдахуйн ухааны докторант

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Б.Жавхлан, СЗСҮТ-ийн Мэдээлэл технологийн мэргэжилтэн

- **“Нэмэлт” товхимол**

Орчуулсан: Д. Тулгамаа, АИФО байгууллагын суурин төлөөлөгч, нийгмийн ухааны магистр, докторант

Хянасан: Л.Энхбуянт, АИФО байгууллагын менежер, нийгмийн ухааны магистр, докторант

С.Баярбат, СЗСҮТ-ийн Бодлогын хэрэгжилт, нийгмийн оролцооны хэлтсийн дарга, хууль зүйн ухааны магистр

Г.Түвшинжаргал, СЗСҮТ-ийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Жавхлан, СЗСҮТ-ийн мэдээлэл технологийн мэргэжилтэн

ХАМТ ОЛОНД ТҮШИГЛЭН СЭРГЭЭН ЗАСАХ ХАНДЛАГЫН УДИРДАМЖ **ТАНИЛЦУУЛГА ТОВХИМОЛ**

Агуулга:

Өмнөх үг.....	05
Талархал.....	06
Хамт олонд түшиглэн сэргээн засах удирдамжийн тухай.....	12
Менежмент.....	34
Үе шат 1: Нөхцөл байдлын дүн шинжилгээ	41
Үе шат 2: Төлөвлөлт ба дизайн.....	48
Үе шат 3: Хэрэгжилт ба мониторинг.....	54
Үе шат 4: Үнэлгээ.....	62
Хавсралт: ХОТСЗ хөтөлбөрт хэрэглэх менежментийн бүтцийн загварууд	

Өмнөх үг

1978 оны Алма – Атагийн тунхаглалаар Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) Хамт олонд түшиглэн сэргээн засах (ХОТСЗ) хандлагыг санаачилсан. Энэ нь бага болон дунд орлоготой орны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сэргээн засах тусламж үйлчилгээний хүртээмжийг орон нутгийн нөөц бололцоог дээд зэргээр ашиглан үзүүлэх стратеги юм. Өнгөрсөн 30 гаруй жилийн хугацаанд НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагууд хамтран ажилласны үр дүнд ХОТСЗ хандлага нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоог баталгаажуулж, нийгэмд хамруулж, амьдралын чанарыг сайжруулж, тэдний хэрэгцээг өргөн хүрээнд авч үздэг олон салбарын стратеги болж хувирсан.

Өнгөрсөн таван жилийн хугацаанд ХОТСЗ хандлагыг хэрэгжүүлдэг гол хүмүүс хамтарч 2003 оны ХОТСЗ хандлагыг тоймлон харах Хелсинкийн Олон улсын зөвлөгөөн, 2004 оны Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ), НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО), ДЭМБ-ын хамтран гаргасан ХОТСЗ хандлагын хамтарсан баримт бичиг дээр үндэслэн ХОТСЗ хандлагын энэхүү удирдамжийг боловсруулж гаргасан юм. ХОТСЗ хандлага нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци болон хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хөгжлийн бэрхшээлийг тэгш хамруулах үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах стратеги гэдгийг энэхүү Удирдамж баталж байна.

Тус удирдамж нь ХОТСЗ менежер, болон бусад хүмүүст ХОТСЗ хөтөлбөрийг хэрхэн боловсронгуй болгох эсвэл бэхжүүлэх, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа болон нийгмийн салбаруудаас ашиг хүртэх боломжийг баталгаажуулах талаар практик зөвлөгөөг өгнө. Мөн удирдамж нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд болон нийт хамт олныг хөгжлийн болон шийдвэр гаргах явцад оролцуулж, тэднийг эрх мэдэлжүүлэхэд онцгой анхаарал тавьсан. Мөн энэхүү удирдамж нь ХОТСЗ хөтөлбөрийг үнэлэх, ХОТСЗ хандлагын үр дүн болон үр нөлөөг олон талаас нь судлах судалгааны ажил зохион байгуулахыг санал болгосон.

Энэхүү бичиг баримтыг боловсруулахад ДЭМБ, ОУХБ, ЮНЕСКО ба Олон улсын хөгжлийн бэрхшээл ба хөгжлийн концерциум (IDDC), CBM, Handicap international, Италийн “Паул Фолерогийн анд нөхдийн холбоо” (АИФО), Light for the World, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн болон хараа хамгаалах Норвегийн нийгэмлэг зэрэг ХОТСЗ хөтөлбөрийг хэрэгжүүлдэг олон байгууллагууд хамтран ажилласан юм. Мөн 180 гаруй хувь хүмүүс ба ихэвчлэн дэлхийн доогуур орлоготой орнуудаас 300 гаруй байгууллагууд оролцсон. Үнэтэй тусламж дэмжлэг, хувь нэмрээ оруулсан бүх хүмүүст бид чин сэтгэлийн талархлаа илэрхийлж байна.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын
Халдварт бус өвчин, Сэтгэцийн эрүүл мэндийн хэлтсийн
Дэд захирал Доктор Ала Алван

Талархал

Хувь нэмрээ оруулагчид

Alireza Ahmadiyeh, Suman Ahmed, Anupam Ahuja, Flavia Ester Anau, Marta Aoki, Shitaye Astawes, Luis Fernando Astorga, Ruma Banerjee, Angelo Barbato, Alcida Perez Barrios, Denise Dias Barros, Mary Basinda, Raymann Beatriz, Beverly Beckles, Herve Bernard, Josse M. Bertolote, Francoise Boivon, Johan Borg, Wim Van Brakel, Vianney Briand, Ron Brouillette, Lissen Bruce, Jill Van den Brule, Stephanie Lucien Brun, Cesar Campoverde, Joan Carey, Lorenzo Carraro, Blanca Castro, Mahesh Chandrasekhar, Gautam Chaudhury, Park Chul-Woo, Denis Compingt, Huib Cornielji, Enrique Coronel, Hannah Corps, Ajit Dalal, Tulika Das, Nan Dengkun, Bishnu Maya Dhungana, Pascal Dreyer, Servious Dube, Marcia Dugan, Livia Elvira Enriquez, Daniel Essy Etya'Ale, Amy Farkas, Harry Finkenflugel, Jonathan Flower, Ruiz Alix Solangel Garcia, Rita Giacaman, Susan Girois, Aloka Guha, Ghada Harami, Sally Hartley, Piet Van Hasselt, Sanae Hayashi, Damien Hazard, Els Heijnen, Sepp Heim, Emma Howell, Patrick Hubert, Shaya A. Ibrahim, Djenena Jalovcic, N. Janardhan, Ivo de Jesus, Zhang Jinming, Donatila Kanyamba, Anita Keller, Jahurul Alam Khandaker, Charles Kilibo, Kalle Konkola, Pim Kuipers, Emmanuel Laerte, Silva Latis, Chris Lavy, Soo Choo Lee, Tirza Leibowitz, Anne Leymat, Yan Lin, Johan Lindeberg, Anna Lindstrom, Graziella Lippolis, Betty MacDonald, Geraldine Maison-Halls, M.N.G. Mani, Steve Mannion, Enzo Martinelli, Gloria Martinez, Phitalis Were Masakhwe, Roy Mersland, Rajanayakam Mohanraj, Ashis K.Mukherjee, Roselyn Mwangi-Wabuge, James Mwesigye, Margaret Naegeli, D.M. Naidu, Alex Ndeezi, Alice Nganwa, Tran Thi Nhieu, Stela Maris Nicolau, Henry Mwizegwa Nyamubi, Lawrence Ofori-Addo, Joan Okune, Fatima Correa Oliver, Francesca Ortali, Parvin Ortogol, Djibril Ouedreagou, R. Pararajasegaram, Istvan Patkai, Carole Patterson, Akhil S.Paul, Norgrove Penny, Hernan SOTO Peral, Debra Perry, Katharina Pfortner, Eric Plantier, Fiona Post, Grant Preston, Bhushan Punani, Sheila Purves Nandini Rawal, Eladio Recabarren, Chen Reis, Ramin Rezaei, Aline Robert, Silvia Rodriguez, Desire Roman, Gonna Rota, Theresa Rouger, Johannes Sannesmoen, Mary Scott, Alaa Sebeh, Tom Shakespeare, Albina Shankar, Valerie Sherrer, Andrew Smith, Sian Tesni, Ongolo Thomas, Florence Thune, Heinz Trebbin, Daniel Tsengu, Veronica Umeasiegbu, Claudie Ung, Isabelle Urseau, Geert Vanneste, Johan Veelma, Rens Verstappen, John Victor, Mary Kennedy Wambui, Sheila Warenbourg, Patrick Wasukira, Terje Watterdal, Marc Wetz, Mary Wickenden, Hu Xiangyang, Miguel Yaber, Veda Zachariah, Daniel Zappala, Tizun Zhao and Tuling Zhu.

Тоймлон харагчид

Kamala Achu, Rosangela Berman-Bieler, Roma Bhattacharjea, Dan Blocka, Jean-Luc Bories, Wim Van Brakel, Matthias Braubach, Svein Brodtkorb, Rudi Coninx, Huib Cornielji, Kenneth Eklindh, Gaspar Fajth, Hetty Fransen, Beth Fuller, Cristina Gallegos, Donna Goodman, Demet Gulaldi, Praveena Gunaratnam, Sally Hartley, Sanae Hayashi, Sayed Jaffar Hussain, Djenana Jalovcic, Aboubacar Kampo,

Etienne Krug, Garren Lumpkin, Chewe Luo, Charlotte McClain-Nhlapo, Asish Kumar Mukherjee, Barbara Murray, Brenda Myers, Kozue Kay Nagata, Alice Nganwa, Kicki Nordstrom, Alana Officer, Hisashi Ogawa, Malcolm Peat, Louise A. Plouffe, Fiona Post, Francesca Racioppi, Pia Rockhold, Hala Sakr, Chamaiparn Santikarn, Benedetto Saraceno, Shekhar Saxena, Helen Schulte, Kit Sinclair, Joe Ubiedo, Nurper Ulkuer, Armando Vasquez and Alexandra Yuster.

Талбар дээр нь тоймлон харсан орнууд

Бангладеш

Хөгжлийн бэрхшээлийн хөгжлийн төв (CDD), Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй ажилладаг байгууллагуудын үндэсний форум (NFOWD).

Буркина Фасо

Centre Opthalmologique de Zorgho, Ouargaye and Garnago-ийн Хамт олонд түшиглэсэн сэргээн засалтын хөтөлбөр (RBC).

Камбоди

Cambodian Development Mission for Disability (CDMD), Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үндэсний төв.

Хятад

Anhui их сургуулийн эмнэлэг, Бээжин их сургуулийн 1-р эмнэлэг, Хятадын сэргээн засалтын анагаах ухааны нийгэмлэг, Хятадын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбоо, Хятадын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбоо (Нийгмийн үйлчилгээний чиглүүлэх төв), Хятадын сэргээн засалтын эрдэм шинжилгээний төв, Хятадын бие бялдрын анагаах ухаан болон сэргээн засалтын нийгэмлэг, Dong Guan хотын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбоо, Guangdong мужийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбоо, Hubei мужийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбоо, Nan Pi мужийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбоо, Shun De дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбоо, Wuhan хотын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбоо, Guangdong мужийн Сэргээн засалтын нийгэмлэг, Guangdong мужийн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сэргээн засалтын төв, Shenzhen-ий хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үйлчилгээний төв, Shun De дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үйлчилгээний төв, Fudan их сургууль – Huashan эмнэлэг, Guangdong сэргээн засалт, эмнэлгийн нийгэмлэг, Guangdong ажилчдын сэргээн засалтын төв, Guangzhou Likang гэр бүлийн хөгжлийн төв, Guangzhou Shi Jia Zuang хотын 1-р эмнэлэг, Hua Zhong-ы Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Jiang Men хотын хойд хэсгийн хамт олны эрүүл мэндийн төв, Kuming анагаахын коллеж 2-р эмнэлэг, Nan Pi, Jin Ya тосгон, Nan Pi, Yu Shan Te тосгон, Хүүхдийг ивээх сан /Англи/, Shenzhen-ий ард түмний 2-р эмнэлэг, Shenzhen-ий ард түмний 9-р эмнэлэг, Shenzhen хотын хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн туслах технологийн хөгжлийн төв, ДЭМБ-тай хамтран ажилладаг сэргээн засалтын төв – Хонг Конгийн сэргээн засалтын нийгэмлэг, ДЭМБ-тай хамтран ажилладаг сэргээн засалтын төв – Sun Yat-Sen-ий

анагаахын шинжлэх ухааны их сургууль, ДЭМБ-тай хамтран ажилладаг сэргээн засалтын эрдэм шинжилгээ, сургалтын төв – Tongji эмнэлэг, Xianning нийгмийн эрүүл мэндийн сургууль, Zhejiang мужийн эмнэлэг, Zhong Shan их сургуулийн 3-р эмнэлэг.

Египет

Каиро хотын Дэмжлэг, Боловсрол, Сургалт, Интеграцын төв.

Этиоп

Arba Minch сэргээн засалтын төв, Этиопын CBM, Этиопын ХОТЦЗ-ын сүлжээ, Этиопын Cheshire Сан – Addis Ababa, Этиопын Cheshire сан – Jimma, Cheshire үйлчилгээ – Dire Dawa, Cheshire үйлчилгээ – Harar, Этиопын Cheshire үйлчилгээ, Этиопын Сонсголгүй иргэдийн үндэсний нийгэмлэг, Этиопын үндэсний хөгжлийн бэрхшээлийн үйл ажиллагааны сүлжээ, Fiche (CBR), Gondar их сургууль (CBR), Gondar их сургууль (Хөдөлгөөн засалын тэнхим), Helpers of Mary, Sako (CBR), Medical Missionaries of Mary, Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн өвчтэй хүүхэд, залуучуудын үндэсний холбоо, Nekemtie (CBR), RAPID (CBR), Rapid Adama (CBR), Сонсголгүй иргэдийн сэргээн засалтын үйлчилгээ.

Гана

Action on Disability and Development (ADD), Agona District Assembly, Bawku эмнэлэг (audiology, хөдөлгөөн засал, ортопедийн тасаг), Нийгмийн халамжийн хэлтэс, Agona дүүргийн Нийгмийн халамжийн хэлтэс, Volta бүсийн Нийгмийн халамжийн хэлтэс, Winneba Нийгмийн халамжийн хэлтэс, District Assembly of Nkwanta, Swedru дүүргийн эрүүл мэндийн захиргаа, Echoing Hills, Garu CBR, Ганагийн хараагүй хүмүүсийн холбоо

– Ga-Adangme, Ганагийн хараагүй хүмүүсийн холбоо (GAB), Ганагийн боловсролын үйлчилгээ (GES), Ганагийн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн холбоо, Ганагийн Сонсголгүй иргэдийн үндэсний холбоо, Ганагийн хараагүй хүмүүсийн нийгэмлэг – Brong Ahafo Region, Ганагийн хараагүй хүмүүсийн нийгэмлэг (GSB), Krachi CBR төсөл, Боловсролын яам, Иргэний боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эцэг эх гэр бүлийн үндэсний зөвлөл, Presbyterian CBR – Garu, Salvation Army – Dunkwa, Salvation Army – Begoro, Salvation Army (Хамт олонд түшиглэн сэргээн засах төсөл), Salvation Army (Сонсголгүй хүмүүсийн интегралчилсан сургууль), Salvation Army (Эмнэлгийн болон нийгмийн үйлчилгээнүүд) – Accra, Sandema Хамт олонд түшиглэн сэргээн засах хөтөлбөр – Баруун дээд бүс, Sightsavers – Хараа хамгаалах байгууллагын орон нутгийн офисс, Sightsavers – Хараа хамгаалах байгууллага Karachi, Sightsavers – Хараа хамгаалах байгууллага Nkwanta, Swedru дүүргийн төлөвлөгөөний ажилтан, Duakwa болон Winneba-гийн Боловсролын их сургуулийн шашны удирдагчид

Гаяана

Хараагүйчүүдийн Карибын зөвлөл, Гаяанагийн Хамт олонд түшиглэн сэргээн засах хөтөлбөр, Эрүүл мэндийн яам, Хөгжлийг бэрхшээлийн үндэсний зөвлөл, Сонсголгүй иргэдийг дэмжих бүлэг.

Энэтхэг

Aaina, Энэтхэгийн хөгжлийн бэрхшээл, хөгжлийн үйл ажиллагаа байгууллага, AIFO байгууллагын Энэтхэг дэх суурин төлөөлөгчийн газар, Энэтхэгийн Basic Needs байгууллага, Энэтхэгийн хараагүйчүүдийн нийгэмлэг, CBM, ХОТСЗ Форум, Бангалорын ХОТСЗ сүлжээ, Cheshire Homes India – Coorg, Хүний эрхийн хуулийн сүлжээ, Leonard Cheshire International, Leonard Cheshire International – Бангалор, Хүний нөөцийн хөгжлийн яам, Нийгмийн шударга байдал, эрх мэдэлжүүлэх яам, Мобилити Индиа, Movement for Rural Emancipation, Narendra сан, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн улсын комиссар, Pallium India, Анагаахын боловсрол, судалгааны сургалтын дараах институт– Чандигарх, Энэтхэгийн сэргээн засалтын зөвлөл, Rohilkhand их сургууль (Institute of Advanced Studies in Education), Saha сан, Sense International – India, SEVA in Action, Хараагүй хүмүүсийн Shree Ramana Maharishi академи, Карнатакагийн саатай хүмүүсийн нийгэмлэг, Тамил Надугийн саатай хүмүүсийн нийгэмлэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмлэг, Viklang Kendra.

Индонез

ХОТСЗ хөгжил, сургалтын төв (CBR-DTC), Өмнөд Сулавезийн ХОТСЗ хөтөлбөр.

Кени

Кенийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмлэг, Кенийн сонсголгүй хүмүүсийн нийгэмлэг, Кенийн анагаахын коллеж, Кенийн хараагүй хүмүүсийн нийгэмлэг, Кенийн хараагүй хүмүүсийн холбоо, Leonard Cheshire Disability – Зүүн хойд Африкийн бүсийн офисс (ENAR), Little Rock ECD, Эрүүл мэндийн яам, Sense International – Зүүн Африк, Кенийн Сайн дурынхны нийгэмлэг (VSO).

Бүгд найрамдах ардчилсан Лаос ард улс

Бельгийн Handicap International – орон нутгийн офисс.

Лебанон

Arc En Ciel, Хамт олонд түшиглэн сэргээн засах нийгэмлэг, Diakonia, Палестины эмэгтэйчүүдийн ерөнхий холбоо, Палестинчуудад эмнэлгийн тусламж, Nahda нийгэмлэг, Норвегийн ард түмний тусламжийн байгууллага, Шведийн хүүхдийн ивээх сан, Норвегийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмлэг.

Малауи

Малауигийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын холбоо (FEDOMA), Малауигийн хүүхдүүдийг хооллох төсөл, Малауигийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зөвлөл (Малауигийн ХОТСЗ үндэсний хөтөлбөрийн нарийн бичгийн газар), Боловсрол, Шинжлэх ухаан, технологийн яам, Хүйсийн болон хүүхдийн хөгжлийн яам, Эрүүл мэндийн яам, Хөдөлмөрийн яам.

Мексик

Pina Palmera.

Монгол

АИФО байгууллагын суурин төлөөлөгчийн газар, Монгол улсын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олонд түшиглэн сэргээн засах “Тэгш Дүүрэн” хөтөлбөр, Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв.

Мяньмар

Дэлхийн зөн International – орон нутгийн офисс.

Никарагуа

Juigalpa ХОТСЗ төсөл.

Палестин

Al-Noor Center, Al-Wafa буяны нийгэмлэг, Al-Wafa эмнэлэг, Al-Widad нийгэмлэг, Atfaluna сонсголгүй хүүхдүүдийн нийгэмлэг, Baituna нийгэмлэг, Bethlehem Арабын сэргээн засалтын нийгэмлэг, Birzeit их сургууль (Нийгмийн эрүүл мэнд, хамт олны институт), ХОТСЗ хөтөлбөр – төв, баруун эрэг, ХОТСЗ хөтөлбөр – баруун хойд эрэг, ХОТСЗ хөтөлбөр – Баруун өмнөд эрэг, Хамт олны коллеж, Diakonia болон Норвегийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмлэг, Газийн сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөр, Хөгжлийн бэрхшээлтэй палестинчуудын холбоо, Сонсголгүй хүмүүсийн олон улсын клуб, Hebron исламын тусламжийн байгууллага, Jabalya нийгэмлэг, Ирусалемийн сэргээн засалтын нийгэмлэг, Олон нийтийн хэвлэл мэдээллийн институт, Палестинчуудад зориулсан эмнэлгийн тусламжийн байгууллага – Англи, Боловсрол, дээд боловсролын яам (Тусгай боловсролын хэлтэс), Эрүүл мэндийн яам (Хямралын менежментийн хэлтэс), Орон нутгийн засгийн газрын яам, Нийгмийн хамгааллын яам, Залуучууд, спортын яам, Хамт олны сэргээн засалтын үндэсний төв, Сэргээн засалтын нийгэмлэг– Палестин, Газийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хороо, Палестиний эмнэлгийн тусламжийн нийгэмлэг, Палестиний Nunchaku холбоо, Хил хязгааргүй эмч нарын нийгэмлэг, A-Iradah радио (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн дуу хоолой), Улаан загалмайн нийгэмлэг, Амьдрах эрх нийгэмлэг, Хүүхдийг ивээх сан – Палестин, Хөгжлийн бэрхшээлийг асрах Shams төв, Хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүсийн нийгэмлэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн спортын холбоо, Итгэл найдварын од нийгэмлэг, ЮНИСЕФ, Нэгдсэн үндэстний байгууллагын тусламжийн агентлаг (сэргээн засалтын хөтөлбөр), ДЭМБ, Wifaq тусламжийн нийгэмлэг.

Папуа Шинэ Гвиней

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Callan үйлчилгээ.

Филиппин

CBM (ХОТСЗ зохицуулах офис), Simon of Cyrene хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн сан, Филиппиний их сургууль, Филиппиний ерөнхий эмнэлэг (Сэргээн засалтын хэлтэс).

Өмнөд Африк

Өмнөд Африкийн Cheshire Homes, ЖАЙКА (Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг) – Өмнөд Африкийн офис, Leonard Cheshire Хөгжлийн бэрхшээл – Өмнөд Африкийн бүсийн офис (SARO), Өмнөд Африкийн засгийн газрын бус байгууллагуудын сүлжээ.

Тайланд

Ази-Номхон далайн хөгжлийн бэрхшээлийн хөгжлийн төв (APCD), Handicap International – Тайланд, ОУХБ-ын бүсийн офисс – Тайланд, Khon Kaen их сургууль (Анагаахын шинжлэх ухааны факультет), Анагаахын сэргээн засалтын үндэсний төв (Нийгмийн эрүүл мэндийн яам), Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрх мэдэлжүүлэх үндэсний офисс.

Уганда

Хөгжлийн бэрхшээл, Хөгжлийн үйл ажиллагаа – Уганда, Busia дүүргийн ХОТСЗ хөтөлбөр, CBM, ХОТСЗ Африкийн сүлжээ, Хамт олонд түшиглэсэн сэргээн засалтын нэгдэл, Германы уяман өвчний тусламжийн нийгэмлэг, GOAL Уганда, Kyambogo их сургууль, Leonard Cheshire Хөгжлийн бэрхшээл – Уганда, Luzira ахлах сургууль, Угандагийн сэтгэцийн эрүүл мэнд, Эрүүл мэндийн яам, Боловсрол, Спортын яам, Хүйс, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Угандагийн сонсголгүй, хараагүй хүмүүсийн үндэсний нийгэмлэг, Угандагийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үндэсний холбоо, Sense International, Sightsavers International – Уганда, ДОХ-ын тусламжийн байгууллага, Угандагийн сонсголгүй хүмүүсийн үндэсний нийгэмлэг, Угандагийн хараагүйчүүдийн сан, Угандагийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн нийгэмлэг.

Вьетнам

CBM, Danang сэргээн засалт, сувиллын эмнэлэг, Bach Mai эмнэлэг (сэргээн засалтын хэлтэс), Нидерландын эмнэлгийн зөвлөл – Вьетнам, Дэлхийн зөн International – Вьетнам.

Зимбабве

Африкийн сэргээн засалтын институт, Cheshire сан, Клиникийн эрдэм шинжилгээний хэлтэс, Уналт таталтад туслах сан, Эрүүл мэндийн яам, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах нийгэмлэгүүдийн үндэсний холбоо, Зимбабвегийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үндэсний зөвлөл, Зимбабвегийн их сургууль, ДЭМБ, Зимбабвегийн нээлттэй их сургууль.

ХОТСЗ хандлагын удирдамжийн тухай

Үндэслэл

Дэлхийн хүн нийт хүн амын дор хаяж 10% нь хөгжлийн бэрхшээлтэй ба ихэнх нь хөгжил буурай оронд ядуу нөхцөлд амьдарч байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь дэлхийн хамгийн эмзэг, хамгийн бага эрх мэдэлжсэн бүлэг хүмүүс байдаг. Тэдний ихэнх нь эрүүл мэнд, боловсрол ба амьжиргааг дээшлүүлэх салбаруудын тусламж үйлчилгээг хүртэх ашиглах боломж нь хязгаарлагдмал ба үргэлж ялгаварлан гадуурхагдаж, муу нэр зүүдэг.

ХОТСЗ хандлагыг анх 1978 онд ДЭМБ Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн талаарх олон улсын бага хурал дээр санаачилсан бөгөөд улмаар энэ нь Алма-Атагийн тунхаглал болон гарсан юм. ХОТСЗ хандлагыг хөгжиж буй орны хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлж буй сэргээн засах тусламж үйлчилгээг сайжруулах стратеги гэж үздэг байсан хэдий ч сүүлийн 30 гаруй жилд түүний цар хүрээ нь өргөн болсон.

2003 онд Хелсинкид болсон ХОТСЗ хандлагыг тоймлон харах олон улсын зөвлөгөөнөөс гол зөвлөмжүүдийг гаргасан. Түүний дараа ОУХБ, ЮНЕСКО, ДЭМБ-ын хамтарч ХОТСЗ хандлагыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олны ерөнхий хөгжлийн дунд сэргээн засах, тэгш боломж олгох, ядуурлыг бууруулах, нийгэмшүүлэх стратеги бичиг баримт гэж дахин тодорхойлсон. 2005 онд Дэлхийн эрүүл мэндийн ассамблей хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх ба сэргээн засах талаар буюу Гишүүн орнуудыг “.....хамт олонд түшиглэн сэргээн засах хөтөлбөрийг дэмжиж, бэхжүүлэх”-ийг шаардсан 58.23 тоот тогтоолыг гаргасан.

Одоогоор 90 гаруй орон ХОТСЗ хандлагыг хэрэгжүүлж байна. Энэ удирдамж ХОТСЗ хандлагыг хэрхэн хөгжүүлэх талаар ХОТСЗ хандлагын гол хүмүүсийн олон хүсэлтэд хариу өгөх ба 30 гаруй жил амьдралд хэрэгжүүлсний дараа хандлагын талаарх нийтлэг ойлголтыг өгнө. Тэд ХОТСЗ хандлагын талаар мэддэг бүхнээ ил гаргаж, үйл ажиллагааны шинэ хүрээ, мөн хэрэгжүүлэх практик саналуудыг энэхүү удирдамжаар нийтэд хүргэж байна. Мөн энэхүү удирдамжийг боловсруулж байх үед батлагдан гарсан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон түүний нэмэлт протоколын агуулгын үзэл санаа энэхүү удирдамжид гүнээ шингэсэн буй.

Удирдамжийн гол зорилго

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц болон ХОТСЗ хандлагын хамтарсан баримт бичигтэй уялдуулан ХОТСЗ хөтөлбөрийг боловсронгуй болгох, бэхжүүлэх талаар чиглэл өгөх
- Хөгжлийн бэрхшээлийг хөгжлийн бусад хөтөлбөрүүдэд, ялангуяа ядуурлыг бууруулах хөтөлбөрт хамруулахад туслахын тулд ХОТСЗ хандлагыг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх стратеги болгох

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа ба нийгмийн салбарын тусламж үйлчилгээнээс хүртэж амьдралын чанараа сайжруулах болон тэдний үндсэн хэрэгцээг хангахад нь гол хүмүүст дэмжлэг үзүүлэх
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг хөгжлийн үйл ажиллагаа болон шийдвэр гаргах явцад оролцуулж, хамруулж тэднийг эрх мэдэлжүүлэхэд гол хүмүүст дэмжлэг үзүүлэх

Удирдамжийг зориулсан гол хүмүүс

ХОТСЗ –ын удирдамжийг судлах анхны хүмүүс нь:

- ХОТСЗ –ын хөтөлбөрийн менежер
-

Дараах судлах хүмүүс нь:

- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд
- Эрүүл мэндийн анхан шатны ажилтнууд, сургуулийн багш нар, нийгмийн ажилтнууд болон бусад хамт олны хөгжлийн ажилтнууд
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллага, өөрөө өөртөө туслах бүлгийн гишүүд
- Хөгжлийн бэрхшээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцож буй төрийн байгууллагын ажилтнууд, ялангуяа орон нутгийн засгийн газрын ажилтнууд болон орон нутгийн манлайлагчид
- Хөгжлийн байгууллагын ажилтнууд, төрийн бус байгууллага, болон ашгийн бус байгууллагуудын ажилтнууд
- Судлаачид ба академчид

Удирдамжийн цар хүрээ

Удирдамж ХОТСЗ хөтөлбөрийн үндсэн гол ойлголтын ерөнхий үзэл санааг, болон зорилго, үр дүнг тодорхойлж, мөн зорилгод хүрэх үйл ажиллагаануудыг санал болгоход гол анхаарлаа хандуулсан. (Удирдамж нь аливаа нэг зүйлийг хийх жор биш буюу энэ нь аливаа онцгойлсон бэрхшээлтэй холбоотой асуултуудад хариулахаар зохиогдсон биш, харин эмнэлгийн болон техникийн зөвлөмж өгөх, эсвэл хөтөлбөрийг хөгжүүлэх болон хэрэгжүүлэхэд алхам алхмаар чиглүүлэхээр загварчлагдсан буй.)

Удирдамж нь 7 салангид номоос бүрдэнэ. Үүнд:

- **Товхимол 1** – Танилцуулга: Хөгжлийн бэрхшээлийн талаарх тойм ойлголт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, ХОТСЗ хандлагын хөгжил, болон ХОТСЗ хандлагын матрицын тухай өгүүлнэ.
- Менежментийн бүлэг: ХОТСЗ хөтөлбөрийг боловсронгуй болгож, бэхжүүлэхтэй холбоотой менежментийн тойргийг тоймлон харуулсан.
- **Товхимол 2-6** – ХОТСЗ хандлагын матрицын 5 бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр тайлбарласан (эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, нийгмнau, эрх мэдэлжүүлэх) 5 номоос бүрдэнэ.
- **Товхимол 7** – Нэмэлт товхимол: Сэтгэцийн эрүүл мэнд, ХДХВ/ДОХ, Уяман өвчин ба Хүмүүнлэгийн тусламж гэсэн дөрвөн онцгой асуудлыг хамарсан бөгөөд эдгээр асуудлуудыг ХОТСЗ хөтөлбөр орхигдуулдаг байсан юм.

Удирдамжийн хөгжлийн үе шатууд

2004 оны 11-р сард энэхүү удирдамжийг бичихийг санаачлах хөгжлийн бэрхшээл ба ХОТСЗ хандлагыг хэрэгжүүлэгч туршлага бүхий 65 экспертүүдийг ОУХБ, ЮНЕСКО, ДЭМБ нар урьсан юм. Тэрхүү бүлэгт ХОТСЗ хандлагын эхлэлийг тавигч анхдагчууд, эмч нар, хөгжлийн бэрхшээлийг биеэрээ туулсан туршлагатай хувь хүмүүс, НҮБ, гишүүн улс болон манлайлж буй олон улсын төрийн бус байгууллагуудын төлөөлөгчид, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд, мэргэжлийн байгууллагууд, болон бусад байгууллагуудын төлөөллүүд оролцсон. Уулзалтын үр дүнд удирдамжийн бүтэц, цар хүрээг тодорхойлсон ХОТСЗ хандлагын матрицын загварыг гаргасан.

Удирдамжийн цааших хөгжлийг Зөвлөх Хороо ба Цөм бүлэг удирдан зохион байгуулж ажилласан. Удирдамж 30 жилийн хуримтлуулсан мэдлэгтэй, дэлхийн зуу гаруй ХОТСЗ хөтөлбөрүүдээс сайн туршлагуудыг цуглуулахыг баталгаажуулахын тулд Цөм Бүлэг доогуур орлоготой орнуудын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эмэгтэйчүүдийн төлөөллийг оролцуулсан өргөн хэмжээний, маш өндөр түвшинд хамтран ажиллах явцыг сонгосон юм. Бичиг баримтын төслийг боловсруулахын тулд хэсэг бүр дээр 2-оос доошгүй манлайлах зохиогчийг сонгосон ба тэд дэлхийн өнцөг бүрийн хүмүүстэй хамтран ажилласан. Нийт 150 гаруй хүмүүс энэхүү удирдамжийн агуулгад хувь нэмрээ оруулсан.

Удирдамжийн агуулгад өргөн хүрээтэй хэвлэгдсэн болон хэвлэлийн бус эх тухайлбал олон улсын болон тухайн хамт олны хөгжлийн хамгийн сайн практик гэж тодорхойлсон, доогуур орлоготой оронд шууд хуулан хэрэгжүүлэх боломжтой, мөн доогуур орлоготой орны ХОТСЗ хөтөлбөрийн гол хүмүүс амархан авах боломжтой эс сурвалжуудаас авсан. ХОТСЗ хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа гол хүмүүсийн жишээнүүдийг тодорхой асуудал дээр дүрслэл бий болгохоор оруулсан. ХОТСЗ-ын нотолгооны нэг чухал хэсэг нь ХОТСЗ хандлагыг ашиглахад тус болох хөгжлийн бэрхшээлтэй амьдардаг хүмүүс, болон олон хувь хүний хүүрнэл өгүүллэгээс бас багтаан оруулсан.

Бичиг баримтын төслийг ДЭМБ-ын бүсүүдийг төлөөлөх 29 оронд талбар дээр нь баталсан. ХОТСЗ хандлагыг хэрэгжүүлдэг 300 гаруй гол хүмүүс энэхүү бичиг баримтын төсөлд санал бодлоо илэрхийлсэн. Үүн дээр үндэслэж Цөм Бүлэг төслийн баримт бичгийг дахин засварлаж, дараа нь туршлагатай хүмүүст болон ХОТСЗ –ын эксперт, шинжээч, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, НҮБ-ын байгууллагууд, академиар шалгуулж, эцсийн засварыг Цөм Бүлэг дахин хийсэн юм.

Удирдамж 2010 оны 5-р сарын 19-нд хэвлэгдэхээр батлагдсан. Удирдамжийн агуулга 2020 он хүртэл хүчин төгөлдөр байхаар хүлээн зөвшөөрөгдсөн ба тоймлон харах хугацааг Женев дэх ДЭМБ –ын Хүчирхийлэл, Гэмтлээс сэргийлэх ба Хөгжлийн бэрхшээлийн хэлтэс санаачилна.

Ашигласан материалууд

1. Хөгжлийн бэрхшээлээс урьдчилан сэргийлэх ба сэргээн засалт: хөгжлийн бэрхшээлээс сэргийлэх ба сэргээн засалтын ДЭМБ-ын хорооны тайлан. Женев. Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, 1981 он (http://whqlibdoc.who.int/trs/WHO_TRS_668.pdf 2010 оны 8-р сарын 10нд хандсан)
2. Алма-Атагийн тунхаглал: Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн талаарх олон улсын бага хурал, Алма Ата, ЗХУ, 1978 оны 9-р сарын 6-12, Женев, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, 1978 он (www.who.int/hpr/NPH/dpcs/declaration_almaata.pdf 2010 оны 8-р сарын 10нд хандсан)
3. Хамт олонд түшиглэн сэргээн засах хандлагыг тоймлон харах олон улсын зөвлөгөөн, Женев, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, 2003 он (http://whqlibdoc.who.int/hq/2003/who_dar_03.2.pdf 2010 оны 8-р сарын 10нд хандсан)
4. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага. ХОТС3: Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг сэргээн засах, тэгш боломж олгох, ядуурлыг бууруулах, нийгэмшүүлэх стратеги. Хамтарсан бичиг баримт 2004. Женев, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, 2004 он (www.who.int/disabilities/publications/cbr/en/index.html 2010 оны 8-р сарын 10нд хандсан)
5. Дэлхийн эрүүл мэндийн 58.23 тоот тогтоол: Хөгжлийн бэрхшээл, түүнээс урьдчилан сэргийлэх, менежмент ба сэргээн засалт. Дэлхийн эрүүл мэндийн тавин наймдугаар ассамблей, Женев, 2005 оны 5-р сарын 25 (www.who.int/disabilities/publications/other/wha5823/en/index.html 2010 оны 8-р сарын 10нд хандсан)
6. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц. Нью Йорк, Нэгдсэн Үндэстэн, 2006 он (www.un.org/disabilities/default.asp?navid=12&pid=150 2010 оны 8-р сарын 10нд хандсан)

Танилцуулга

Агуулгын хувьсал

Хөгжлийн бэрхшээлийг одоо хэрхэн харж байгааг ойлгохын тулд түүнийг эдүгээг хүртэл хэрхэн хувьсаж өөрчлөгдөж ирснийг ойлгох нь чухал. Түүхийн үүднээс хөгжлийн бэрхшээлийг домгийн болон шашны талаас нь илүү өргөн харж үзэж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг чөтгөр болон сүнсэнд эзэмдүүлсэн гэж үздэг байсан. Мөн тэднийг ихэвчлэн өнгөрсөн үедээ хийсэн буруу зүйлийнхээ шийтгэлийг хүртэж байна гэж боддог байсан. Энэ үзэл бодол одоог хүртэл олон хуучны ёс заншилтай нийгэмд байсаар байна.

Арван ес, хорьдугаар зууны үед янз бүрийн эрүүл мэндийн нөхцөл байдлуудтай хамтарч хүний биеийн бүтэц болон үйлдэлд бий болсон ямар нэгэн алдагдал үүсдэг /импэйрмент/ гэж шинжлэх ухаан, анагаах ухаан биологийн болон эмнэлгийн үүднээс тайлбарласан. Энэхүү эмнэлгийн загвар нь хөгжлийн бэрхшээлийг хувь хүний асуудал гэж үзэж, нэн тэргүүнд түүнийг мэргэжилтнүүд анагаах, эмнэлгийн тусламж үзүүлдэг.

Дараа нь 1960, 1970-аад оны үеэс хөгжлийн бэрхшээлийг хувь хүн болон эмнэлгийн зүгээс анхаарч үзэхэд учир дутагдалтай болж, хөгжлийн бэрхшээлийг нийгмийн талаас нь харах нийгмийн загвар үүссэн. Энэ хандлага нь хөгжлийн бэрхшээлийн эмнэлгийн загвараас анхаарлыг холдуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ялгаварлан гадуурхах, нийгмийн саад бэрхшээлүүдэд анхаарлыг хандуулсан. Хөгжлийн бэрхшээлийг хувь хүний асуудлаас илүү нийгмийн асуудал гэж дахин тодорхойлсон бөгөөд зөвхөн эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх биш нийгмийн өөрчлөлт болон саад бэрхшээлүүдийг арилгахад анхаарлыг хандуулсан.

Дээрх өөрчлөлтийн эхлэл нь 1960–аад оны сүүлчээр Хойд Америк болон Европын орнуудад үүссэн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөдөлгөөн эхэлсэн бөгөөд түүнээс хойш дэлхий нийтийн хөдөлгөөн болсон. “Бидэнгүйгээр бидний тухай юу ч байхгүй” гэсэн алдарт уриа нь эдгээр хөдөлгөөнүүд хэрхэн нөлөөлснийг харуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө, тэдэнтэй хамтарч, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдөө бүрэн дүүрэн оролцох, тэгш боломжтой байхад анхаарлаа хандуулж байна. Тэд хөгжлийн бэрхшээлийн хүний эрхийн загварт шилжихэд дэмжлэг үзүүлсэн Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг боловсруулахад гол үүрэг гүйцэтгэсэн.



Жишээ 1 Иран

Хамтын ажиллагааг сайжруулах замаар хүмүүсийг эрх мэдэлжүүлэх

1992 онд Исламын Бүгд Найрамдах Иран улсын засгийн газар 2 бүс нутагт ХОТСЗ хөтөлбөрийг туршилтын журмаар хэрэгжүүлсэн. Хөтөлбөр амжилттай хэрэгжиж, 1994 он гэхэд 6 мужийн зургаан бүс нутгийг хамарч хүрээгээ тэлсэн. 2006 он гэхэд бүх 30 мужийг хамарсан үндэсний хөтөлбөр болсон. Нийгмийн Халамжийн яамны харьяа Нийгмийн Халамжийн Газар нь ХОТСЗ хөтөлбөрийг бүх орон даяар хариуцан ажилладаг бөгөөд хамт олны ажилтан, ХОТСЗ хөтөлбөрийн дунд түвшний ажилтан, их эмч, ХОТСЗ хөтөлбөрийн эксперт, болон ХОТСЗ хөтөлбөрийн менежер зэрэг 6000 гаруй ажилтан ХОТСЗ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцсон.

ХОТСЗ үндэсний хөтөлбөрийн эрхэм зорилго нь “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл болон хамт олныг арьс өнгө, шашин шүтлэг, хүйс, нас, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр болон шалтгаанаас үл хамааран ойлголт нэмэгдүүлэх, бүх үйлчилгээнд тэгш хамруулах, ядуурлыг бууруулах, буруу бодлыг арилгах, үндсэн хэрэгцээг хангах, мөн амьжиргаа, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг хүртэхэд чиглүүлэх зэргээр эрх мэдэлжүүлэх”-д оршино.

Энэ хөтөлбөр нь “ХОТСЗ хотын төв”-өөс зохион байгуулж буй ихэнх үйл ажиллагааг орон нутгийн түвшинд шилжүүлж, төвлөрлийг сааруулсан. Энэхүү төвүүд нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг хөдөө орон нутагт үзүүлдэг “тосгоны эрүүл мэндийн төв” болон хот суурин газрын “эрүүл мэндийн пост”-уудтай нягт хамтран ажилладаг. Эдгээр байгууллагуудын эрүүл мэндийн ажилтнуудыг ХОТСЗ хандлагын стратеги, үндэсний хөтөлбөрийн баримжаа олгох нэгээс хоёр долоо хоногийн сургалтанд хамруулснаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илрүүлэх, мөн тэдгээрийг ойролцоох ХОТСЗ-ын хотын төвүүдэд зуучилж өгдөг болсон.

ХОТСЗ хөтөлбөрийн гол үйл ажиллагаанууд:

- ДЭМБ –ын ХОТСЗ –ын сургалтын багц гарын авлагыг ашиглан гэр бүл болон хамт олны гишүүдийг хөгжлийн бэрхшээл болон ХОТСЗ хандлагын талаар сургах
- Боловсролын дэмжлэг үзүүлэх, багш, оюутнуудын чадавхыг сайжруулж хамран сургалтыг чиглүүлэх, мөн байшин барилгад орох дэд бүтцийг сайжруулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөдөлгөөн засалч, хэл засалч, ахуй засалчдын үзүүлдэг мэс засал болон сэргээн засалтын үйлчилгээнд зуучлах
- Таяг, тэргэнцэр, сонсголын аппарат, нүдний шил зэрэг туслах хэрэгслээр хангах
- Сургалтанд хамруулах, ажилд сургах, орлого нэмэгдүүлэх зорилгоор санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллах боломжийг бий болгох
- Биеийн тамир спорт, амралт гэх мэт нийгмийн үйл ажиллагаануудад дэмжлэг үзүүлэх
- Гэр орноо тохируулж засварлах, боловсрол эзэмших, амьдралаа дээшлүүлэхэд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх

ХОТСЗ үндэсний хөтөлбөр 1992 оноос хойш 229 мянга гаруй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст дэмжлэг үзүүлсэн. Одоогоор хөтөлбөрт хөдөө орон нутгийн 51% хамрагдсан ба 2011 он гэхэд бүх тосгон суурин газруудыг хамруулах зорилго тавин ажиллаж байна. Хөгжлийн салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, Иранд ХОТСЗ хандлага урагш хөгжихийг баталгаажуулах зорилгоор ХОТСЗ хөтөлбөрийн зөвлөлүүд байгуулагдсаар байна.

Одоо мөрдөж буй тодорхойлолтууд

Дээр дурдсанчлан хөгжлийн бэрхшээлийн талаарх олон өнцгөөс харж тайлбарласан олон янзын тодорхойлолтууд байдаг. Хамгийн сүүлийн үеийн тодорхойлолтуудыг доор өгүүлсэн байна. Үүнд:

- Үйлдэл, Хөгжлийн бэрхшээл ба Эрүүл мэндийн талаарх олон улсын ангилалд (ICF) хөгжлийн бэрхшээлийг хувь хүний эрүүл мэндийн байдал, орчны (хүрээлэн буй орчин тойрон, хандлага гэх мэт) болон хувийн хүчин зүйлсийн (нас, хүйс гэх мэт) хоорондын харилцан хамаарлын үндсэн дээр үүсдэг “биеийн /эрхтэн системийн/ бүрэн бүтэн байдлын алдагдал (импэйрмент), үйл ажиллагааны ба оролцооны хязгаарлалт” гэж тодорхойлсон.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод хөгжлийн бэрхшээлийг “биеийн /эрхтэн системийн/ бүрэн бүтэн байдал нь алдагдсан (импэйрмент) хүмүүс хандлагын болон орчны саад бэрхшээлтэй учирч, тэр нь түүнийг бусдын нэгэн адил нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцоход нь саад болдог” гэж тодорхойлсон.

Хүмүүсийн хөгжлийн бэрхшээлийн талаарх туршлага нь маш их өөр өөр байдаг. Олон янзын шалтгааны улмаас болж хүмүүсийн биеийн бүрэн бүтэн байдалд ямар нэгэн алдагдал үүсдэг /импэйрмент/. Зарим хүмүүс нэг төрлийн бэрхшээлтэй байдаг, зарим нь хавсарсан, зарим нь төрөлхийн, зарим нь амьдралын явцад бэрхшээлтэй болдог. Жишээ нь: тархины саа гэх мэтийн төрөлхийн бэрхшээлтэй төрсөн хүүхэд, тэсрэх бөмбөгөнд өртөж хөлөө алдсан залуу цэрэг, чихрийн шижинтэй болж хараагүй болсон дунд насны эмэгтэй, сэтгэцийн олдмол өвчинтэй өндөр настай хүмүүс бүгдийг хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж тодорхойлдог. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг “удаан хугацааны туршид бие эрхтэн, сэтгэц, оюун ухаан, мэдрэхүйн алдагдалтай /импэйрмент/ хүн” гэж тодорхойлсон.

Дэлхийн чиг хандлага

Дэлхий дээр хөгжлийн бэрхшээлд хүргэдэг нийтлэг шалтгаанууд байдаг. Үүнд: архаг өвчин (чихрийн шижин, зүрх судасны өвчин, хавдар гэх мэт), гэмтэл (зам тээврийн осол, зөрчилдөөн, унах ба тэсрэх бөмбөг гэх мэтээс үүссэн гэмтэл), сэтгэцийн эрүүл мэндийн асуудал, төрөх үеийн гажиг, согог, хоол тэжээлийн дутагдал, ХДХВ/ДОХ болон бусад халдварт өвчнүүд. Дэлхий даяар амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нарийвчилсан тоог тооцож гаргахад их хүндрэлтэй байдаг боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо дараах хүчин зүйлүүдээс хамаарч өсөж байдаг. Үүнд: хүн амын өсөлт, архаг өвчний өсөлт, хүмүүсийн насжилт, эмнэлгийн тусламж үйлчилгээний үр дүнд амьдрал нь уртсах. Доогуур болон дунд орлоготой ихэнх орнуудад давхар ачаалал тулгардаг. Тэдэнд хоол тэжээлийн дутагдал, халдварт өвчинд гэх мэт суурь асуудлууд, архаг өвчлөл бүхий шинэ асуудлууд тулгардаг.

Жишээ 2

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх дэлхийн статистик

- Ойролцоогоор дэлхийн нийт хүн амын 10 % нь хөгжлийн бэрхшээлтэй байдаг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нь дэлхийн цөөнхийн ихэнхийг бүрдүүлдэг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ойролцоогоор 80% нь хөгжиж буй оронд амьдардаг.
- Ойролцоогоор дэлхийн нэн ядуу хүмүүсийн 15-20% хөгжлийн бэрхшээлтэй байна.
- 62 оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс сэргээн засах тусламж үйлчилгээг авах боломжгүй байна.
- Хөгжиж буй оронд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн зөвхөн 5 – 15% нь туслах хэрэгсэл хэрэглэж байна.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд бусад хүүхдүүдтэй харьцуулахад маш цөөхөн бага хэсэг нь сургуульд хамрагдаж байна. Жишээ нь: Малауи, Танзаны бүгд найрамдах улсад хэрэв хүүхдүүд хөгжлийн бэрхшээлтэй бол хэзээ ч сургуульд хамрагдаж чадахгүй байх магадлал нь 2 дахин ихэсдэг.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусад хүмүүсийг бодвол ажилгүй байх нь их бөгөөд хөгжлийн бэрхшээлгүй хүмүүсээс илүү доогуур орлоготой байдаг.

Хөгжил

Ядуурал ба хөгжлийн бэрхшээл

Ядуурал нь зөвхөн мөнгө орлогогүй байхаас илүү маш олон чиг хандлагатай байдаг. “Ядуурал нь хүмүүсийн эрүүл байх эрх, тохирох орон сууцтай байх, аюулгүй хоол ундтай байх, мөн боловсрох эрх гэх мэт нийгэм, эдийн засгийн эрхийг байхгүй болгож эсвэл сүйтгэдэг. Мөн үүний нэгэн адил шударга шүүх хуралд оролцох эрх, улс төрийн оролцоо, хувь хүний аюулгүй байдал зэрэг улс төр, иргэний эрхийг байхгүй болгодог.

“Хэн нэгнийг бид ядуурлаас татаж гаргаж чадвал бид хүний эрхийг хамгаалж байна. Харин бид энэ үүргээ биелүүлж чадахгүй бол хүний эрхийг алдаж байна” -НҮБ –ын ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Анан

Ядуурал нь хөгжлийн бэрхшээлийн үр дагавар болон шалтгаан нь байдаг: Ядуу хүмүүс хөгжлийн бэрхшээлтэй болох магадлал их байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ядуу байх магадлал их байдаг. Бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ядуу байдаггүй. Доогуур орлоготой орнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ядуу хүмүүсийн ихэнх хувийг эзэлдэг. Тэд нар ихэнхдээ анхаарлаас гадуур байж, ялгаварлан гадуурхагдаж, хөгжлийн үйл ажиллагаанаас хасагддаг бөгөөд боловсрол, эрүүл мэнд, орон сууц, амьжиргааг дээшлүүлэх боломжуудаас хүртэх хандлага бага байдаг. Эдгээр нь ядуурлыг ихэсгэж, тусгаарлагдаж мөн эрт үхэхэд хүргэдэг. Эмчилгээ, сэргээн засах эмчилгээ, туслах хэрэгслийн зардал нь олон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ядуурлын тойрогт ороход мөн нөлөөлдөг.

Ямар ч улсад ядуурлын эрсдэлийг бууруулах тодорхой үе шаттай алхам хийх нь хөгжлийн бэрхшээлд анхаарлаа хандуулж буй хэлбэр юм. Мөн ядууралд анхаарлаа хандуулах нь хөгжлийн бэрхшээлийг бууруулж буй хэлбэр юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулснаар ядуурлыг бууруулдаг бөгөөд энэ нь ХОТСЗ хөтөлбөрийн гол зорилгуудын нэг нь бөгөөд эрүүл мэнд, боловсрол, амьжиргааны боломжуудыг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй болгож ядуурлыг бууруулдаг.

Жишээ 3

Селамын амьдралын шинэ хэв маяг

Найман наснаас эхлэн Селам толгой өвдөж байна гэж гомдоллодог байлаа. Түүний гэр бүл юу хийхээ мэдэхгүй байв. Тэгээд түүнийг сүм рүү ариун рашаан уулгахаар хэд хэдэн удаа явуулсан. Селамд ариун рашаан ямар ч нөлөө үзүүлсэнгүй. Селамын хараа нь аажмаар муудаж эхлэв. Нэг өдөр Селам орон нутгийн эрүүл мэндийн төвийн нүдний тасагт очив. Түүний энд эмчлэхэд хэтэрхий хүнд байсан тул түүнийг нийслэлд байдаг төв эмнэлэг рүү зуучлав. Нэгдсэн эмнэлэгт очиж үзүүлэхэд хагалгаанд орох хүлээлгийн жагсаалтад бүртгэж авав. Жилээс илүү хугацаа өнгөрсөн боловч түүний үзүүлэх хугацаа нь болоогүй л байлаа. Ядуу амьдралын улмаас түүний гэр бүл нь хувийн эмнэлэгт хагалгаанд оруулах боломжгүй байв. Хүлээлгэд байх эхний үед Селам бага зэрэг хардаг байв. Хугацаа өнгөрөх тусам тэр бараг харахгүй болов. Түүний хөгжлийн бэрхшээл, ядуу зүдүү байдлын улмаас сургуульдаа үргэлжлүүлэн сурч чадаагүй, түүний улмаас Селам сэтгэл санааны гүн хямралд орсон. Тэр бүрэн тусгаарлагдаж, гэртээ байнга байж, найз нөхдүүдээсээ холдсон. Энэ байдал нь гэр бүлдээ маш их ачаалал өгч, гэр бүл нь түүний төлөө юу хийхээ мэдэхээ болсон. Түүний толгойн өвчин ихсэж, бөөлжиж эхлэн, тэнцвэрээ алдаж, бараг үхэх дөхөв.

ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан Селамыг мэдрэлийн мэс засалчид үзүүлж, түүнд хоргүй хавдар – менингиома байгааг тодорхойлсон. Селам хагалгаанд орж, хавдрыг авав. Эмнэлгийн удирдлага болон нийгмийн сан хагалгааны зардлын 75%-ийг, ХОТСЗ хөтөлбөр үлдсэн 25%-ийг төлөөд, мөн гэр бүлийн гишүүдэд хоол, байр, тээврийн зардлыг олгосон. Одоо Селам дээрх асуудлуудаас ангижирсан. Гэвч ядуугийн улмаас үйлчилгээ оройтож авсан учраас тэр бараг хараагүй болсон. ХОТСЗ ажилтны явуулын сургалтын ачаар Селам бие даан явж, улмаар брайль бичгийг сурсанаар сургуульдаа эргэн суралцах болсон.

ХОТСЗ хөтөлбөр хэрэгжүүлсний ачаар Селамын амьдралын чанар эрс өөрчлөгдөж, гэр бүлдээ дарамт учруулахаа больсон. Энэ бүгд нь Селам болон түүний гэр бүл зуучлах төвтэй холбогдож эмнэлгийн удирдлага болон мэргэжилтнүүдтэй хамтарч ажилласны үр дүн юм.



Мянганы хөгжлийн зорилтууд

2000 оны 09-р сард НҮБ-ын гишүүн орнууд 2015 он гэхэд өлсгөлөн, ядуурлыг бууруулахаас авахуулаад бүх нийтийн анхан шатны боловсрол олгох хүртэл хүрээг хамарсан Мянганы Хөгжлийн найман Зорилтыг баталсан билээ. Олон улсын төвшинд хүлээн зөвшөөрөгдсөн эдгээр хөгжлийн зорилтууд нь шинэ зууны эхэнд тавигдаж байгаа хөгжлийн үе шатыг илэрхийлж байна. Мянганы Хөгжлийн Зорилтууд нь хөгжлийн бэрхшээлийн асуудлыг шууд илэрхийлээгүй боловч зорилт бүр нь хөгжлийн бэрхшээлийн асуудалтай сууриараа холбогдсон байдаг ба хөгжлийн бэрхшээлийн асуудлыг авч үзэхгүйгээр бүрэн хэрэгжих боломжгүй юм. Иймд 2009 оны 11-р сард НҮБ-ын 64 дүгээр ассамблей Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг Мянганы Хөгжлийн Зорилтод хамруулах (A/RES/64/131) тогтоол баталсан.

Жишээ 4

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн оролцоо, Дэлхийн банк

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ерөнхий хөгжлийн үйл ажиллагаанд хамруулахгүй бол 2000 оны 09-р сард болсон НҮБ-ын Мянганы чуулганд оролцсон дэлхийн 180 гаруй орны удирдагч нар зөвшөөрч баталсан зорилтод буй 2015 он гэхэд ядуурлыг тал хувиар бууруулж эсвэл охид хөвгүүд бүр анхан шатны боловсролыг эзэмшиж чадахгүй”.

-Дэлхийн банкны ерөнхийлөгч асан Жеймс Волфенсон, Вашингтон Пост сонин,
2002 оны 12-р сарын 3

Хөгжлийн бэрхшээлийг хамруулсан хөгжил

Хамруулан хөгжүүлэх гэдэг нь хүн бүрийг оролцуулах ба ялангуяа үргэлж ялгаварлан гадуурхагдаж буй хүмүүсийг татан оролцуулж хөгжүүлэхийг хэлнэ. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ба тэдний гэр бүлийн гишүүд, ялангуяа алс хол эсвэл хөдөө орон нутаг эсвэл хотын удам дамжсан ядуучуудын хороололд амьдардаг хүмүүс хөгжлийн үйл ажиллагаанаас ашиг хүртэж чаддаггүй, тиймээс хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулан хөгжүүлэх нь тэднийг бодлого болон хөгжлийн үйл явцад зорилготойгоор оролцохыг нь баталгаажуулахад чухал юм.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн хөтөлбөрийн гольдролд (эсвэл хамруулах) оруулах нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох арга зам юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш боломжоор хангаж, эрх тэгш хувь нэмрээ оруулж, хөгжлийн үйл ажиллагаанаас ашиг хүртэж, шийдвэр гаргахад оролцуулахын тулд хос хандлагыг хэрэглэх шаардлагатай байж болох юм. Хос хандлага нь дараах чиг үүргийг хангаж өгнө. Үүнд: (1) хөгжлийн хөтөлбөрийн зонхилох чиг үүрэгт хөгжлийн бэрхшээлийн асуудлуудыг идэвхтэйгээр авч үзэх, (2) шаардлагатай үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх. Энэхүү удирдамжид нарийвчлан орсон ХОТСЗ хөтөлбөрийн санал болгосон үйл ажиллагаанууд нь энэ хандлага дээр тулгуурласан байдаг.

Хөгжилд хүрэх хамт олонд түшиглэсэн хандлагууд

Бодлого боловсруулагчдаас гаргасан хөгжлийн санаачлагууд нь голдуу дээрээсээ доош чиглэсэн байдаг. Энэ нь хамт олны санал бодлыг тусгаж чадаагүй ангид байдаг. Хөгжлийн үндсэн элементүүдийн нэг нь хувь хүн, бүлэг хүмүүс, байгууллага, хамт олныг хөгжлийн явцын бүх үе шат болох төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналтын үйл ажиллагаанд оролцуулах гэдгийг ойлгож авсан. Хамт олонд түшиглэсэн хандлага нь хөгжлийг ядууст болон анхаарлаас гадуур байгаа хүмүүст хүрэхийг баталгаажуулж, мөн илүү хамруулсан, бодит, тогтвортой санаа санаачлагуудад чиглүүлэхэд тус дөхөм болно. Олон байгууллага, агентлагууд хамт олонд түшиглэсэн хөгжлийн хандлагыг дэмжин ажилладаг. Тухайлбал Дэлхийн банк хамт олонд түшиглэсэн хөгжлийг дэмждэг. Мөн Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага Хамт олонд түшиглэсэн санаачлагуудыг дэмждэг.



Хүний эрх

Хүний эрх гэж юу вэ?

Хүний эрх нь бүх хүмүүст зориулсан олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт юм. Хүн бүр яс үндэс, нас хүйс, гарал үүсэл, арьсны өнгө, оршин буй газар, шашин шүтлэг болон бусад байдлаас үл хамааран тэгш эрхтэй – өөрөөр хэлбэл сурч боловсрох эрхтэй, хоол хүнс, орон байраар хангагдаж, тохирох нийгмийн хамгаалал хүртэх эрхтэй. Эдгээр эрхүүд нь 1948 онд НҮБ –ын гишүүн орнуудаар хүлээн зөвшөөрөгдсөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалд болон зарим нэг онцгой бүлэг хүмүүс, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх хүний эрхийн бусад олон улсын гэрээнд баталгаажсан байдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц

2006 оны 12-р сарын 13-ны өдөр НҮБ–ын Ерөнхий ассамблейгаас Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг баталсан. Конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн олон жилийн үйл ажиллагааны үр дүнд гарсан бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох НҮБ-ын стандарт дүрэм (1993) болон Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх Үйл ажиллагааны дэлхийн хөтөлбөр (1982) дээр түшиглэж, бидний мөрддөг хүний эрхийн талаарх зүйл заалтуудыг дэмжсэн бичиг баримт юм. Конвенцыг засгийн газар, үндэсний хүний эрхийн институт, төрийн бус байгууллага болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн хороо боловсруулсан. Зорилго нь “бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үндсэн эрх чөлөө, хүний бүх эрхээ бүрэн дүүрэн, тэгш эдлэхэд нь дэмжиж, хамгаалж, баталгаажуулж, мөн тэдний эрхэм зэргийг хүндэтгэн үзэхийг дэмжих”-д оршиж байна (1-р Зүйл).

Жишээ 5

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн шинэ эрин үе

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ –ын конвенц нь дэлхий даяар амьдарч байгаа 650 сая хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө шинэ эрин үеийн эхлэлийг илэрхийлж байна.”

—Копи Аннан, НҮБ –ын ерөнхий нарийн бичгийн дарга асан

Конвенц нь Улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг баталгаажуулахад арга хэмжээ авах ёстой хэд хэдэн гол салбарыг хамарсан. Үүнд: хүртээмж, хувь хүний хөдөлгөөн, боловсрол, эрүүл мэнд, сэргээн засалт, хөдөлмөр эрхлэлт гэх мэт. Энэ конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө ямар нэгэн шинэ эрхийг бий болгож өгөөгүй – тэд бусдын нэгэн адил ижил тэгш эрх эдэлдэг – харин хүний эрхийг хөгжлийн бэрхшээлтэй хүнд ээлтэй, хүртээмжтэй, тэднийг хамруулдаг болгож өгсөн.

Хөгжилд хүрэх хүний эрхэд түшиглэсэн хандлага

Хүний эрх ба хөгжил нь ойр нягт холбоотой - хүний эрх нь хөгжлийн үндсэн суурь болж өгдөг. Хөгжил нь хүний эрхийг таних арга зам нь болдог. Үүний үр дүнд олон байгууллага, албан газрууд өөрсдийнхөө хөгжлийн хөтөлбөртөө хүний эрхэд суурилсан хандлагыг өргөн хэрэглэдэг болсон. Хэдийгээр хүний эрхэд суурилсан хандлагыг ашиглаж хөгжилд хүргэх нийтлэг жор байхгүй боловч Нэгдсэн Үндэстэн энэ хандлагын хэд хэдэн чухал онцлог чанарыг тодорхойлсон байдаг. Үүнд:

- **Хүний эрхийг хэрэгжүүлэх** – хөгжлийн хөтөлбөр болон бодлогын үндсэн гол зорилго нь хүний эрхийг хэрэгжүүлэх ёстой.
- **Тодорхой зарчим, стандартыг дагаж мөрдөх** – Олон улсын хүний эрхийн гэрээ хэлэлцээрийн зарчим, стандартууд нь бүх салбарт (эрүүл мэнд, боловсрол гэх мэт) болон хөтөлбөрийн явцын (нөхцөл байдлын дүн шинжилгээ, төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах, үнэлгээ хийх) (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцын ерөнхий зарчим бүхий Жишээ 6-г үзнэ үү) бүх үе шатанд хөгжлийн хамтын ажиллагааг чиглүүлж өгөх ёстой.
- **Тодорхой эрх эдлэгч ба үүрэг хүлээгч** – Эрхээ эдлэгч гэдэг нь эрхээр хангагдсан хүмүүсийг хэлнэ. Жишээ нь хүүхдүүд сурч боловсрох эрхтэй учир тэд эрхээ эдлэгч болно. Үүрэг хүлээгч нь эрхээ эдлэгч хүмүүсийг эрхээ эдлэхийг нь баталгаажуулах хариуцлага хүлээж буй хүмүүс болон байгууллагыг хэлнэ. Жишээ нь: боловсролын яам хүүхдүүдийг боловсрол эзэмшүүлэх үүрэг хүлээж буй учир үүрэг хүлээгч болно, мөн эцэг эхчүүд хүүхдүүдээ сургуульд явахад нь дэмжлэг үзүүлж байх ёстой учир тэд мөн үүрэг хүлээгч болно.



Хамт олонд түшиглэн сэргээн засах

Анхны жилүүд

1978 оны Алма-Атагийн тунхаглал нь ДЭМБ –ын “Бүх нийтээрээ эрүүл байх” гэсэн зорилгод хүрэх үндсэн стратеги нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ гэдгийг дэмжсэн олон улсын анхны тунхаг бичиг байсан. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ нь хүн бүрт баян, ядуу гэж ялгалгүй хүрэхийг зорьдог бөгөөд хувь хүний эрүүл мэндийг хамгийн дээд түвшинд хүргэхэд шаардлагатай нөхцөл байдал, үйлчилгээг хүргэх боломжтой юм.

Алма-Атагийн тунхаглалын дагуу ДЭМБ ХОТСЗ хандлагыг танилцуулсан. Эхэн үедээ ХОТСЗ нь эрүүл мэндийн анхан шатны тусламж болон хамт олны нөөц бололцоог дээд хэмжээгээр ашиглаж үйлчилгээг хүргэж, доогуур орлоготой оронд амьдарч буй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст эрүүл мэндийн анхан шатны тусламж, сэргээн засах тусламж үйлчилгээг ойртуулах зорилготой байсан. Олон орнуудад (Исламын Бүгд Найрамдах Иран улс, Монгол улс, Өмнөд Африк, Вьетнам) Эрүүл Мэндийн Яам нь эрүүл мэндийн анхан шатны тусламжийн ажилтнуудыг ашиглаж ХОТСЗ хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байдаг. ХОТСЗ хөтөлбөр нь эхэн үедээ хөдөлгөөн засал, туслах хэрэгсэл, эмнэлгийн эсвэл мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлэхэд анхаарлаа хандуулж байсан. Мөн зарим нь орлого нэмэгдүүлэх хөтөлбөр болон чадваржуулах сургалтуудаар амьжиргааны боломж болон боловсролын үйл ажиллагааг танилцуулсан байдаг.

1989 онд ДЭМБ ХОТСЗ хөтөлбөр болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүд, сургуулийн багш нар, орон нутгийн зохицуулагч нар болон хамт олны сэргээн засах ХОТСЗ хөтөлбөрийн хорооны гишүүд зэрэг гол хүмүүст дэмжлэг үзүүлэх, удирдамж өгөх зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олны дунд сургах нь гарын авлагыг гаргасан. Энэхүү гарын авлагыг 50 гаруй хэлээр орчуулж, одоог хүртэл доогуур орлоготой олон орнуудад хэрэглэж байгаа ХОТСЗ –ын чухал баримт бичиг болсон хэвээр байна. Үүнээс гадна Хөгжлийн бэрхшээлтэй тосгоны хүүхдүүд: Хамт олны эрүүл мэндийн ажилтнууд, сэргээн засалтын ажилтнууд, болон гэр бүлийн гишүүдэд зориулсан гарын авлага нь ХОТСЗ хөтөлбөрийг доогуур орлоготой орнуудад хөгжүүлэхэд чухал хувь нэмрээ оруулсан.

1990 –ээд оны үеэс ХОТСЗ хөтөлбөрийн тоо хэмжээ ихсэхийн зэрэгцээ ХОТСЗ –ын үзэл баримтлалд агуулгын хувьд өөрчлөлт гарсан. Олон улсын Хөдөлмөрийн байгууллага (ОУХБ), НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага (ЮНЕСКО), НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), НҮБ-ын хүүхдийн сан (ЮНИСЕФ) зэрэг НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд энэхүү хандлагыг олон салбарын хандлага болгоход хамтран оролцсон. 1994 онд ОУХБ, ЮНЕСКО, ДЭМБ хамтарч ХОТСЗ хандлагын анхны хамтарсан бичиг баримтыг гаргасан.

НХОТСЗ хандлагыг 25 жилийн дараа тоймлон харахад

2003 оны 5-р сард ДЭМБ НҮБ-ын төрөлжсөн байгууллагууд, засгийн газрууд, болог олон улсын төрийн бус байгууллагууд, олон улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудтай хамтарч ХОТСЗ хандлагыг тоймлон харах Олон улсын зөвлөгөөнийг Финляндын Хельсинк хотод зохион байгуулсан. Уг зөвлөгөөнөөс ХОТСЗ хөтөлбөрийг дараах чиглэлд анхаарлаа хандуулахыг зөвлөсөн. Үүнд:

- Хөгжлийн бэрхшээлийн үр дагавар, гол тодорхойлогч хүчин зүйл болж буй ядуурлыг бууруулах;
- Хамт олны оролцоо, өөрийн болгох байдлыг дэмжих;
- Олон талын салбарын хамтын үйл ажиллагааг хөгжүүлж, бэхжүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн байгууллагуудыг хөтөлбөрт хамруулах;
- Хөтөлбөрийн цар хүрээг нэмэгдүүлэх;
- Нотолгоонд тулгуурласан практикийг дэмжих;

ХОТСЗ хандлагын хамтарсан бичиг баримт

2004 онд Хелсенкийн зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд ОУХБ, ЮНЕСКО, ДЭМБ ХОТСЗ хандлагын хамтарсан бичиг баримтыг анх удаа гаргасан. Энэхүү бичиг баримт нь үйлчилгээ хүргэхээс эхлэн хамт олны хөгжил хүртэл ХОТСЗ хандлагын хувьсал өөрчлөлтийг тусгасан. ХОТСЗ хандлагыг “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамт олны ерөнхий хөгжлийн дунд нь сэргээн засах, ядуурлыг бууруулах, тэгш боломж олгох, нийгэмшүүлэх стратеги” гэж дахин тодорхойлсон. Мөн ХОТСЗ хөтөлбөрийг “хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд, байгууллага, хамт олон, болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын үзүүлдэг эрүүл мэнд, боловсрол, мэргэжлийн үйлчилгээ, нийгмийн болон бусад үйлчилгээнүүдийн хамтын хүчин чармайлтаар дамжуулж” хэрэгжүүлэхийг дэмжинэ.

Хамтарсан бичиг баримт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрийн амьдарч байгаа газартаа байгаа хамт олны эрүүл мэндийн үйлчилгээ, хүүхдийн эрүүл мэнд, нийгмийн халамж, боловсролын хөтөлбөрүүд г.м бүх үйлчилгээнд ижил тэгш хамруулахыг чухалчилсан. Мөн энэ бичиг баримт нь хүний эрх, ядуурлын эсрэг үйл ажиллагааг дэмжих, засгийн газрын дэмжлэгийг авах, үндэсний бодлогыг хөгжүүлэх зэргийг онцлон тэмдэглэсэн.

ХОТСЗ хандлага өнөөдөр

ХОТСЗ хандлагын матриц

ХОТСЗ хандлагыг олон салбарын хөгжлийн стратеги гэж үзэх болсон үед 2004 онд ХОТСЗ хөтөлбөрүүдийн нийтлэг дүр зургийг гаргах үүднээс матрицыг боловсруулсан юм. Энэхүү матриц нь таван үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй – эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, нийгмийн, эрх мэдэлжүүлэх. Бүрэлдэхүүн тус бүр таван элементтэй. Эхний дөрвөн бүрэлдэхүүн хэсэг нь хөгжлийн гол салбаруудтай холбоотой бөгөөд ХОТСЗ-ын олон салбарын хамтын ажиллагаанд анхаарлаа хандуулж буйг илтгэж байна. Харин сүүлийн бүрэлдэхүүн хэсэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг хангаж, амьдралын чанарыг дээшлүүлэхэд хөгжлийн бүх салбарт хүрэх үндэс нь буюу

хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл, хамт олныг эрх мэдэлжүүлэхтэй холбоотой.

ХОТСЗ хөтөлбөр нь энэхүү матрицад орсон бүрэлдэхүүн, элемент бүрийг хэрэгжүүлэх албагүй. Харин энэхүү матрицыг тухайн орон өөрийн орон нутгийн хэрэгжээ, шаардлага, нөөц бололцоо зэрэгт нийцэх тэрхүү сонголтыг хийхэд тус болохоор зохиогдсон юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгайлсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд ХОТСЗ хөтөлбөр өөрийн хөтөлбөрт хамрагдаагүй салбараас хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд ашиг хүртэхийг баталгаажуулахын тулд бусад байгууллага, салбартай хамтарч, нэгдэж ажиллах хэрэгтэй.

ХОТСЗ хандлагын матриц



ХОТСЗ хандлагын зарчим

ХОТСЗ хандлагын зарчим нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцын зарчим дээр суурилсан. Мөн өөрөө өөрийгөө өмгөөлөх, хамгаалах утга бүхий эрх мэдэлжүүлэх болон тогтвортой байдлын зарчим дээр тулгуурласан байдаг. Эдгээр зарчмууд ХОТСЗ хандлагыг бүх хэлбэрээр хөгжүүлж, чиглүүлэхэд ашиглагдана.

Жишээ 6

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, 3-р зүйл: Ерөнхий зарчим

- a) Сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан салшгүй эрхэм зэрэг, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх
- b) Алагчлахгүй байх
- c) Нийгэм бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах
- d) Ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүний ялгаатай байдлын нэг хэлбэр гэж хүлээн авах
- e) Тэгш боломж олгох
- f) Хүртээмжтэй байх
- g) Эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш байх
- h) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэн хандах

Урагш тэмүүлэх

ХОТСЗ хандлага нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг хэрэгжүүлэх практик стратеги болох мөн хамт олонд түшиглэн хамруулан хөгжихөд, ХОТСЗ хөтөлбөрийг урагш тэмүүлэхэд нь ХОТСЗ хандлагын удирдамж тусална. ХОТСЗ хандлага нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцыг хамт олны түвшинд өөрчлөлт гаргахыг баталгаажуулах салбар хоорондын, доороос дээшээ чиглэсэн стратеги юм. Конвенц бол философи, бодлогыг гаргадаг бол ХОТСЗ нь түүнийг хэрэгжүүлэх практик стратеги юм. ХОТСЗ хандлагын үйл ажиллагаанууд нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн үндсэн хэрэгцээг хангах, ядуурлыг бууруулах, эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа болон нийгмийн боломжуудад хүрэх зэрэг Конвенцын зорилгуудыг биелүүлэх үйл ажиллагаанууд байдаг.

ХОТСЗ хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хөгжлийн үйл ажиллагаанд холбож өгдөг. ХОТСЗ хандлагын удирдамж нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг эрх мэдэлжүүлж, нийгмийг “бүх нийтийг хамруулсан нийгэм” болгоход шаардлагатай хөгжлийн гол салбаруудыг онилж байна. Хамт олны оролцоо хөгжлийн гол элемент учраас энэхүү удирдамж нь ХОТСЗ хөтөлбөрүүдийн хамт олныг оролцуулж урагш хөдлөх шаардлагатайг онцлон тэмдэглэж байна.

Жишээ 7

ХОТСЗ өөрчилж чадна

ХОТСЗ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст Конвенцын ашиг тус дараах байдлаар хүрэхэд тус болж чадна. Үүнд:

- **Конвенцийг таньж мэдэх** – конвенцыг идэвхтэй дэмжиж, хүмүүст ойлгоход нт туслах;
- **Хамтран ажиллах** – Конвенцыг хэрэгжүүлэхийн тулд төрийн бус байгууллага, ХБИБ, орон нутгийн засаг захиргаатай хамтран ажиллах;

- **Нөлөөлөл** - эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт үэрэг салбаруудын бодлого болон алагчлалын эсрэг хуулийг боловсруулах эсвэл сайжруулах зорилгоор нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах;
- **Орон нутаг, үндэсний түвшнийг зохицуулах** – орон нутгийн болон үндэсний төвшинд ярилцлага зохион байгуулах, ХБИБ-ууд болон орон нутгийн бүлгүүдийг бэхжүүлж, орон нутгийн болон үндэсний төвшинд голлох үүрэг гүйцэтгэх;
- **Үйл ажиллагааны төлөвлөгөөнд мониторинг хийхэд нь туслах** – хөгжлийн бэрхшээлийг үндэсний бодлогод оруулах, салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулахад шаардлагатай нөөц бололцоог төлөвлөх болон бодит, үр дүнтэй ажил хийх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад хувь нэмрээ оруулах;
- **Хөтөлбөрийн үйл ажиллагаа** – бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ядуу, хөдөө орон нутагт амьдарч байгаагаас үл хамааран эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа болон нийгмийн үйлчилгээнүүдийг хүртэхэд зориулагдсан үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх.

Судалгаа ба нотолгоо

Энэхүү удирдамжид хэлснээр ХОТСЗ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг хөгжлийн үйл ажиллагаанд хамруулах олон салбарын стратеги юм. ХОТСЗ-ын үр ашиг, ашиг тусын талаар нотолгоо маш хязгаарлагдмал байгаа нь судлаач нарт хүндрэл учруулж байгаа хэдий ч албан ёсны судалгаа, хөгжлийн бэрхшээл ба ХОТСЗ-аас хуримтлуулсан туршлага, ХОТСЗ хөтөлбөрүүдийн үнэлгээ болон олон улсын хөгжлийн салбарт олсон сайн жишээнүүдээс нотолгоог хуримтлуулж байна.

Сүүлийн жилүүдэд хөгжиж байгаа орнуудад ХОТСЗ-ын тоон болон чанарын судалгаа нэмэгдэж байна. ХОТСЗ хандлагын хувь хүний биш албан ёсоор хэвлэгдсэн судалгаануудаас дараах ишлэлүүдийг дурдаж болно:

- ХОТСЗ хөтөлбөрүүд маш үр дүнтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн бие даах байдал нэмэгдэж, хөдөлгөөн сайжирч, харилцааны чадвар дээшилсэн. Мөн ХОТСЗ хөтөлбөр өртөг хямд байдаг.
- Өндөр хөгжилтэй орнуудад тархины гэмтлийг сэргээн засах хамт олонд түшиглэсэн хандлагын талаарх судалгаанаас харахад энэ нь уламжлалт аргаас илүү үр дүнтэй байгаа бөгөөд сэтгэц нийгмийн хувьд өндөр үр дүнтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн хүлээн авах байдал нь илүү байна.
- ХОТСЗ хөтөлбөрийн хүрээнд авч байгаа амьжиргаа дээшлүүлэх үйл ажиллагаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн орлогыг нэмэгдүүлж, өөртөө итгэх итгэл нэмэгдэж, нийгэмших ажиллагаа нь илүү сайн байна.



- Боловсролын хувьд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, насанд хүрсэн хүмүүсийг хамрагдахад тохируулга хийж дэмжиж байна.
- ХОТСЗ хандлага нь үйлчилгээ үзүүлж буй хамт олны ажилтнуудыг сургалтад хамруулж байна.
- Өндөх хөгжилтэй орнуудад хийсэн судалгаанаас харахад ХОТСЗ хөтөлбөрийн үйл ажиллагаа нь хамт олны хандлагад нөлөө үзүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэмшүүлэхэд эерэг өөрчлөлт бий болгож, нийгмийн хувьд эерэг үр дүн гаргаж байна.

Ашигласан материалууд

1. Convention on the Rights of Persons with Disabilities. New York, United Nations, 2006 (www.un.org/esa/socdev/enable/rights/convtexte.htm, accessed 18 June 2010).
2. International classification of functioning, disability and health (ICF). Geneva, World Health Organization, 2001 (www.who.int/classifications/icf/en/, accessed 18 June 2010).
3. Disability and rehabilitation: WHO action plan 2006–2011. Geneva, World Health Organization, 2006(www.who.int/disabilities/publications/dar_action_plan_2006to2011.pdf, accessed 18 June 2010).
4. Disability prevention and rehabilitation: report of the WHO expert committee on disability prevention and rehabilitation. Geneva, World Health Organization, 1981 (www.who.int/disabilities/publications/care/en/index.html, accessed 18 June 2010).
5. Convention on the Rights of Persons with Disabilities: some facts about disability. New York, United Nations, 2006 (www.un.org/disabilities/convention/facts.shtml, accessed 18 June 2010).
6. Elwan A. Poverty and disability: a survey of the literature. Washington, DC, The World Bank, 1999 (<http://siteresources.worldbank.org/DISABILITY/Resources/280658-1172608138489/PovertyDisabElwan.pdf>, accessed 18 June 2010), accessed 18 June 2010).
7. Global survey on government action on the implementation of the Standard Rules on the Equalization of Opportunities for Persons with Disabilities. UN Special Rapporteur on Disability, 2006 (www.escwa.un.org/divisions/sdd/news/GlobalSurvey_Report_Jan30_07_ReadOnly.pdf).
8. Assistive devices/technologies: what WHO is doing. Geneva, World Health Organization (undated) (www.who.int/disabilities/technology/activities/en/, accessed 18 June 2010).
9. EFA global monitoring report: reaching the marginalized. Paris, United Nations Educational Scientific and Cultural Organization, 2009 (<http://unesdoc.unesco.org/images/0018/001866/186606E.pdf>, accessed 18 June 2010).
10. Facts on disability in the world of work. Geneva, International Labour Organization, 2007 (www.ilo.org/public/english/region/asro/bangkok/ability/download/facts.pdf, accessed 18 June 2010).
11. Human rights dimension of poverty. Geneva, Office of the High Commissioner for Human Rights(undated) (www2.ohchr.org/english/issues/poverty/index.htm, accessed 18 June 2010).
12. Disability, poverty and development. UK, Department for International Development, 2000 (www.make-development-inclusive.org/docsen/DFIDdisabilityPovertyDev.pdf , accessed 18 June 2010).

13. Millennium development goals. New York, United Nations, 2000 (www.un.org/millenniumgoals, accessed 18 June 2010).
14. Disability and the MDGs. Brussels, International Disability and Development Consortium, 2009 (www.includeeverybody.org/disability.php, accessed 18 June 2010).
15. Realizing the millennium development goals for persons with disabilities (UN General Assembly Resolution A/RES/64/131). New York, United Nations, 2009 (www.un.org/disabilities/default.asp?id=36).
16. Inclusive development. New York, United Nations Development Programme (undated) (www.undp.org/poverty/focus_inclusive_development.shtml, accessed 18 June 2010).
17. Inclusive development and the comprehensive and integral international convention on the protection and promotion of the rights and dignity of persons with disabilities (International disability and development consortium reflection paper: Contribution for the 5th Session of the Ad Hoc Committee, January 2005). International Disability and Development Consortium, 2005. (<http://hpod.pmhclients.com/pdf/lord-inclusive-development.pdf>, accessed 18 June 2010).
18. Mainstreaming disability in the development agenda. New York, United Nations, 2008 (www.un.org/disabilities/default.asp?id=708, accessed 18 June 2010).
19. A guidance paper for an inclusive local development policy. Handicap International, Swedish Organisations' of Persons with Disabilities International Aid Association, and the Swedish Disability Federation, 2008 (www.make-development-inclusive.org/toolsen/inclusivedevelopmentweben.pdf, accessed 18 June 2010).
20. Community driven development: overview. Washington, DC, The World Bank (undated) (<http://web.worldbank.org/WBSITE/EXTERNAL/TOPICS/EXTSOCIALDEVELOPMENT/EXTCDD/0,,contentMDK:20250804~menuPK:535770~pagePK:148956~piPK:216618~theSitePK:430161,00.html>, accessed 18 June 2010).
21. Community-based initiative (CBI). Cairo, WHO Regional Office for the Eastern Mediterranean, 2009 (<http://www.emro.who.int/cbi/>, accessed 18 June 2010).
22. Human rights, health and poverty reduction strategies. Geneva, World Health Organization, 2008. (http://www.ohchr.org/Documents/Publications/HHR_PovertyReductionsStrategies_WHO_EN.pdf, accessed 18 June 2010).
23. Your human rights. Geneva, Office of the High Commissioner for Human Rights (undated) (www.ohchr.org/en/issues/Pages/WhatareHumanRights.aspx, accessed 18 June 2010).
24. Declaration of Human Rights. United Nations, 1948 (www.un.org/en/documents/udhr/index.shtml, accessed 18 June 2010).
25. The Standard Rules on the Equalization of Opportunities for Persons with Disabilities. New York, United Nations, 1993 (www.un.org/esa/socdev/enable/dissre00.htm, accessed 18 June 2010).

26. World Programme of Action Concerning Disabled Persons. New York, United Nations, 1982 (<http://www.un.org/disabilities/default.asp?id=23>, accessed 18 June 2010).
27. Human development report 2000: Human rights and human development. New York, United Nations Development Programme, 2000 (<http://hdr.undp.org/en/reports/global/hdr2000/>, accessed 18 June 2010).
28. Frequently asked questions on a human rights-based approach to development cooperation. Geneva, Office of the High Commissioner for Human Rights, 2006 (www.un.org/depts/dhl/humanrights/toc/toc9.pdf, accessed 18 June 2010).
29. Declaration of Alma-Ata: international conference on primary health care, USSR, 6–12 September 1978. Geneva, World Health Organization, 1978 (www.who.int/hpr/NPH/docs/declaration_almaata.pdf, accessed 18 June 2010).
30. Primary health care. Geneva, World Health Organization (undated) (www.who.int/topics/primary_health_care/en/, accessed 18 June 2010).
31. Helander et al. Training in the community for people with disabilities. Geneva, World Health Organization, 1989 (www.who.int/disabilities/publications/cbr/training/en/index.html, accessed 18 June 2010).
32. Werner D. Disabled village children. Berkeley, CA, Hesperian Foundation, 2009 (www.hesperian.org/publications_download_DVC.php, accessed 30 May 2010).
33. International consultation to review community-based rehabilitation (Report of a meeting held in Helsinki, Finland, 2003). Geneva, World Health Organization, 2003 (http://whqlibdoc.who.int/hq/2003/WHO_DAR_03.2.pdf, accessed 18 June 2010).
34. CBR: A strategy for rehabilitation, equalization of opportunities, poverty reduction and social inclusion of people with disabilities (Joint Position Paper 2004). Geneva, International Labour Organization, United Nations Educational, Scientific and Cultural Organization, and World Health Organization, 2004 (www.who.int/disabilities/publications/cbr/en/index.html, accessed 18 June 2010).
35. Finkenflugel H, Wolffers I, Huijsman R. The evidence base for community-based rehabilitation: a literature review. *International Journal of Rehabilitation Research*, 2005, 28:187–201.
36. Mitchell R. The research base of community based rehabilitation. *Disability and Rehabilitation*, 1999, 21(10–11):459–468.
37. Wiley-Exley E. Evaluations of community mental health care in low- and middle-income countries: a 10-year review of the literature. *Social Science and Medicine*, 2007, 64:1231–1241.
38. Mannan H, Turnbull A. A review of community based rehabilitation evaluations: Quality of life as an outcome measure for future evaluations. *Asia Pacific Disability Rehabilitation Journal*, 2007, 18(1):29–45.
39. Velema JP, Ebenso B, Fuzikawa PL. Evidence for the effectiveness of rehabilitation-in-the- community programmes. *Leprosy Review*, 2008, 79:65–82.
40. Barnes MP, Radermacher H. Neurological rehabilitation in the community. *Journal of Rehabilitation Medicine*, 2001, 33(6):244–248.
41. Chard SE. Community neurorehabilitation: A synthesis of current evidence and

- future research directions. *NeuroRx*, 2006, 3(4):525–534.
42. Evans L, Brewis C. The efficacy of community-based rehabilitation programmes for adults with TBI. *International Journal of Therapy and Rehabilitation*, 2008, 15(10):446–458.
43. Doig E et al (under review). Comparison of rehabilitation outcomes in day hospital and home settings for people with acquired brain injury: a systematic review. *Neurorehabilitation and Neural Repair*.
44. De Klerk T. Funding for self-employment of people with disabilities. Grants, loans, revolving funds or linkage with microfinance programmes. *Leprosy Review*, 2008, 79(1):92–109.

Уншихыг зөвлөж буй материалууд

A handbook on mainstreaming disability. London, Voluntary Service Overseas, 2006 (www.asksource.info/pdf/33903_vsomainstreamingdisability_2006.pdf, accessed 18 June 2010).

ABC: teaching human rights (Practical activities for primary and secondary schools). Geneva, Office of the High Commissioner for Human Rights, 2003. (<http://www.ohchr.org/EN/PUBLICATIONSRESOURCES/Pages/TrainingEducation.aspx>, accessed 18 June 2010).

Biwako Millennium Framework for Action towards an Inclusive, Barrier-free and Rights-based Society for Persons with Disabilities in Asia and the Pacific. Bangkok, Economic and Social Commission for Asia and the Pacific, 2003 (<http://www.unescap.org/esid/psis/disability/>, accessed 18 June 2010).

Convention on the Rights of Persons with Disabilities (A teaching kit and complementary resources). Lyon, Handicap International, 2007 (www.hadicap-international.fr/kit-pedagogique/indexen.html, accessed 18 June 2010).

Disability, including prevention, management and rehabilitation (World Health Assembly Resolution 58.23). Geneva, World Health Organization, 2005 (http://www.who.int/disabilities/WHA5823_resolution_en.pdf, accessed 18 June 2010).

Disability Knowledge and Research (KaR) website. (www.disabilitykar.net/index.html, accessed 18 June 2010).

Griffo G, Ortali F. Training manual on the human rights of persons with disabilities. Bologna, AIFO, 2007 (www.aifo.it/english/resources/online/books/cbr/manual_human_rights-disability-eng07.pdf, accessed 18 June 2010).

Hartley S (Ed). CBR as part of community development – a poverty reduction strategy. University College London, 2006.

Helander E. Prejudice and dignity: An introduction to community-based rehabilitation. United Nations Development Programme, 2nd edition, 1999 (www.einarhelander.com/PD-overview.pdf, accessed 18 June 2010).

Italian Association Amici di Raoul Follereau (AIFO) website. (www.aifo.it/english/resources/online/books/cbr/cbr.htm, accessed 18 June 2010).

Making PRSP inclusive website. (www.making-prsp-inclusive.org/fr/accueil.html, accessed 18 June 2010).

Poverty Reduction Strategy Papers (PRSP). Washington, DC, International Monetary Fund, 2010 (www.imf.org/external/np/exr/facts/prsp.htm, accessed 18 June 2010).
The build-for-all reference manual. Luxembourg, Build-for All, 2006 (www.build-for-all.net/en/documents/, accessed 18 June 2010).

Танилцуулга

Энэхүү танилцуулга хэсэгт тодорхойлсон Хамт олонд түшиглэн сэргээн засах (ХОТСЗ) матрицад таван бүрэлдэхүүн хэсэг (Эрүүл мэнд, Боловсрол, Амьжиргаа, Нийгмийн, Эрх мэдэлжүүлэх) болон түүний элементүүд орно. Энэ нь шинээр ХОТСЗ хөтөлбөр эхлүүлэхэд үндсэн хүрээг л санал болгож байгаа юм. Нийтлэг ашиглагдах матриц байгаа хэдий ч ХОТСЗ хөтөлбөр бүхэн хоорондоо харилцан адилгүй байдаг. Үүнд бие махбодын, нийгэм эдийн засгийн, соёлын, улс төрийн гээд маш өргөн хүрээний хүчин зүйлс нөлөөлдөг. Энэ товхимол нь хөтөлбөрийн менежерүүдэд ХОТСЗ хөтөлбөртөө холбогдолтой, орон нутгийн хэрэгцээ, нэн тэргүүний зорилтууд, нөөц бололцоондоо тохирох бүрэлдэхүүн хэсэг, элементийг хэрхэн сонгох талаар үндсэн ойлголт өгөх зааварчилгаа юм.

ХОТСЗ бүх хөтөлбөрүүд өөр хэдий ч хөгжлийг чиглүүлэх үе шатлалын нийтлэг дараалал байдаг. Эдгээр үе шатлалыг нийлүүлээд менежментийн цикл гэх бөгөөд үүнд: Нөхцөл байдлын дүн шинжилгээ (1 дүгээр шат), Төлөвлөлт ба дизайн (2 дугаар шат), Хэрэгжилт ба мониторинг (3 дугаар шат), Үнэлгээ (4 дүгээр шат). Энэ товхимол нь хөтөлбөрийн менежерүүдэд үе шат тус бүрийн чухал зүйлүүдийг ойлгоход нь туслахын тулд, мөн бүх гол хүмүүсийг оролцуулан үр дүнтэй хөтөлбөр боловсруулахын тулд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг хангахын тулд менежментийн циклийг илүү дэлгэрэнгүй тайлбарлана.

Энэхүү товхимолд санал болгож буй зүйл нь ХОТСЗ хөтөлбөр бүрийн заавал дагаж мөрдөх ёстой тогтсон хандлага биш гэдгийг ойлгох нь зүйтэй. Хөтөлбөрийг засгийн газар, эсвэл санхүүжүүлэгч байгууллагын хамтын ажиллагаатай боловсруулдаг. Тиймээс энэ нь хөтөлбөрийг боловсруулахад удирдамж, зааварчилгаа болж болно. Мөн энэ нь шинээр боловсруулж буй ХОТСЗ хөтөлбөрт голцуу анхаарлаа хандуулсан хэдий ч одоо хэрэгжиж байгаа хөтөлбөрийг сайжруулахад чухал ач холбогдолтой.



Жишээ 8 Энэтхэг

Хамруулсан нийгэм бий болгох

Мобилити Индия бол Энэтхэгийн Бангалор хотод байгуулагдсан төрийн бус байгууллага юм. 1999 онд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс тэгш эрхтэй байж, чанартай амьдардаг болгож хамруулсан нийгэм байгуулах зорилготойгоор ХОТСЗ хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн. Мобилити Индия нь ХОТСЗ хөтөлбөрийг гурван газарт хэрэгжүүлсэн: 1) Бангалор хотын ядуусын хороолол; 2) Бангалороос 35 км-ийн зайд орших Анекал талук; 3) Бангалороос 210 км-ийн зайд орших Чамражнагар дүүрэг.

Эдгээр газруудад ХОТСЗ хөтөлбөрийг хэрэгжүүлсэн: өөрөө өөртөө туслах бүлэг байгуулахад нь чиглүүлэх, эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, нийгмийн боломжуудаа хүртэхэд нь туслах, хамт олныг хөдөлгөөнд оруулах зэрэг ижил төстэй үйл ажиллагаа явуулж байсан хэдий ч тухайн газрын онцлогийг харгалзан үзэж дахин давтагдашгүй зүйлүүдийг ч хийж байсан.

Эдгээр жилүүдийн хугацаанд Мобилити Индия нь үнэлж баршгүй менежментийн хичээлүүдийг сурсан:

- Менежментийн циклийн бүх төвшинд гол хүмүүсийг оролцуулах;
- ХОТСЗ хөтөлбөр эхлэхийн өмнө нөхцөл байдлын дүн шинжилгээг үнэн зөв хийх;
- Анхны төлөвлөлтөө хийхдээ тодорхой үзүүлэлт бүхий сайн төлөвлөлт хийж, бодитоор хувь нэмрээ оруулах;
- Гол хүмүүстэй хамтран ажиллах, тэдний үүрэг, хариуцлагыг тодорхой болгох – орон нутгийн засгийн газрын түншлэл маш чухал;
- Зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүн биш хамт олон бүхэлдээ ашиг хүртэх үйл ажиллагааг санаачлах;
- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтанг тухайн орон нутгаас авах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, ялангуяа эмэгтэйчүүдийг ажилтан болоход илүүд үзэх;
- Чадавх бэхжүүлэх нь байнгын үргэлжилж байдаг процесс бөгөөд хүн бүрийг (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд, хамт олны гишүүд, үйлчилгээ үзүүлэгч, орон нутгийн манлайлагчид, шийдвэр гаргагчид) хамруулах;
- Амжилт үр дүн, алдаа оноогоо бусадтай хуваалцах



Гол ойлголтууд

ХОТСЗ төсөл, ХОТСЗ хөтөлбөрийн хооронд ямар ялгаа байгаа вэ?

Дэлхий дээр ХОТСЗ төсөл, ХОТСЗ хөтөлбөр гэж хэрэгждэг хэдий ч хүмүүс энэ хоёрын ялгааг сайн мэддэггүй. ХОТСЗ төсөл нь ихэнхдээ жижиг, ХОТСЗ-ын матрицын зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсэг дээр (тухайлбал: эрүүл мэнд) маш онцгойлсон үр дүнд хүрэхэд анхаарлаа хандуулдаг. Энэ нь богино хугацаатай буюу эхлэх цэг, дуусгавах болгох цэгтэй байдаг. ХОТСЗ-д засгийн газрын дэмжлэг маш хязгаарлагдмал байгаа нөхцөлд төслийг орон нутгийн бүлэг эсвэл төрийн бус байгууллага хэрэгжүүлж эхлүүлдэг. Аргентин, Бутан, Колумб, Шри Ланка, Ираны исламын бүгд найрамдах улс ингэж хэрэгжүүлсэн байдаг. ХОТСЗ хөтөлбөр гэхээр илүү зохион байгуулалттай аргаар хэд хэдэн төсөл хэрэгжүүлэхийг хэлнэ. Энэ нь ихэнхдээ удаан хэрэгждэг, дуусгавар болох эцсийн хугацаагүй, илүү өргөн хүрээг хамардаг, төслөөс илүү цогц байдаг. Төсөл, хөтөлбөр хоёр хоорондоо ялгагдах ялгаатай хэдий ч энэхүү товхимолд “хөтөлбөр” гэсэн нэрээр хоёулангийн нь төлөөлж хэрэглэсэн. Энэ товхимолд яригдах менежментийн цикл, үр дүн, гол ойлголт, санал болгож буй үйл ажиллагаануудыг ХОТСЗ удирдамжийн бусад бүрэлдэхүүн хэсгүүд дээр дурдсан.

Эхлэх

ХОТСЗ-ыг ихэнхдээ хамт олны гаднаас, тухайлбал яам, эсвэл төрийн бус байгууллагууд санаачилдаг. Хамт олны дотроо эсвэл гаднаас үүссэн аль нь ч байсан бай нөөц бололцоо нь олдоцтой, хамт олон хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд бэлэн байх хэрэгтэй (Оролцоог хангасан менежментийг уншина уу). Яам, хэлтэс, газар, орон нутгийн захиргаа, эсвэл байгууллагын аль нь ХОТСЗын матрицийн аль нь бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлж болно. Хамгийн чухал нь матрицын бүрэлдэхүүн тус бүрийг хэрэгжүүлэхдээ өөр бусад гол хүмүүстэй хамтарч, иж бүрэн хөтөлбөрийг боловсруулах хэрэгтэй. Хөтөлбөр, үйлчилгээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд, хамт олны хэрэгцээнд хариу өгсөн, хамруулахад салбар бүр хариуцлага хүлээдэг байх ёстой. Тухайлбал, эрүүл мэндийн яам ба/эсвэл төрийн бус байгууллага эрүүл мэндийн салбар дээр хамтарч эрүүл мэндийн бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэхэд хариуцлага хүлээж болно. Боловсролын яам ба/эсвэл төрийн бус байгууллага боловсролын салбар дээр хамтарч боловсролын бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлэхэд хариуцлага хүлээж болно гэх мэт.

Газар зүйн хамралт

ХОТСЗ нь орон нутгийн, бүсийн, үндэсний байж болно. Газар зүйн хамрагдалт нь хөтөлбөрийг хэн хэрэгжүүлэх, ямар арга хэмжээг ямар салбарт авах, ямар нөөц бололцоо байгаа зэргээс хамаарна. Хамгийн гол нь аливаа дэмжлэг тусламж хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн амьдарч байгаа газар нутагт, ялангуяа хөдөө орон нутагт аль болохоор ойр байх ёстой. Ихэнх хөгжиж байгаа оронд нөөц бололцоо хязгаарлагдмал, бүх үйлчилгээ нийслэл хот эсвэл томоохон хотуудад төвлөрсөн байдаг. ХОТСЗ-ыг төлөвлөж байгаа хүмүүсийн хувьд тухайн орон нутгийн нөхцөл байдал, одоо байгаа нөөц бололцоо, хэрэгцээний бодит зэрэгт үндэслэн чанартай үйлчилгээг тухайн хүний гэр оронд аль болох ойр байлгахгаар шийдвэр гаргах нь чухал юм (1 дүгээр шат: Нөхцөл байдлын дүн шинжилгээ-г уншина уу)

ХОТСЗ хөтөлбөрийн менежментийн бүтэц

ХОТСЗ хөтөлбөр өөрийнхөө хөтөлбөрийг хэрхэн удирдахаа өөрсдөө шийддэг учир энэ бүрэлдэхүүн хэсэгт ХОТСЗ-ын нэг ерөнхий менежментийн бүтэц байх боломжгүй. Гэхдээ дэлхий дээр хэрэгжиж байгаа ХОТСЗ хөтөлбөрүүдийн менежментийн бүтцийн зарим жишээг энэхүү товхимлын төгсгөлд дурдсан (Хавсралтыг үзнэ үү)

Ихэнх нөхцөл байдалд ХОТСЗ хөтөлбөрийг удирдах Хороог байгуулдаг. Хороонд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд, хамт олны сонирхсон гишүүд, төрийн байгууллагуудын төлөөлөл зэрэг байдаг. Энэ нь дараах зүйлүүдийг хийхэд хэрэгтэй байдаг:

- ХОТСЗ хөтөлбөрийн алсын хараа, зорилгыг тодорхойлох;
- Хэрэгцээ болон орон нутгийн нөөц бололцоог илрүүлэх;
- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд, гол хүмүүсийн үүрэг, хариуцлагыг тодорхойлох;
- Үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нөөц бололцоог дайчлах;
- ХОТСЗ хөтөлбөрийн менежерүүдэд туслах, удирдамж зааварчилгаагаар хангах.



Оролцоог хангасан менежмент

Бүх ХОТСЗ хөтөлбөрүүдийг урагш явуулж байдаг зүйл нь оролцоо юм. Ихэнх тохиолдолд ХОТСЗ хөтөлбөрийн менежерүүд эцсийн шийдвэр гаргадаг боловч бүх гол хүмүүс, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд, менежментийн циклийн бүх шатанд идэвхтэйгээр оролцох нь чухал. Гол хүмүүс туршлага, ажигласан зүйл, зөвлөгөөгөө хуваалцаж үнэтэй хувь нэмэр оруулж чадна. Менежментийн циклд тэд оролцсоноор хөтөлбөр хамт олны хэрэгцээнд хариу үзүүлж, хамт олон хөтөлбөрийг урт удаан хугацаанд тогтвортой байлгахад тусалдаг (1 дүгээр шат: Гол хүмүүсийг шинжлэх нь уншина уу)

ХОТСЗ хөтөлбөрийг тогтвортой байлгах

ХОТСЗ хөтөлбөрийг эхлүүлэх сайхан санаачилга гарснаар тэр нь хэзээ ч өөрөө хэрэгжиж, тогтвортой болдоггүй. Ерөнхийдөө туршлагаас харахад засгийн газрын тэргүүлдэг эсвэл засгийн газрын дэмжлэгтэй хөтөлбөрийг иргэний нийгмийн хөтөлбөрүүдтэй харьцуулахад нөөц бололцоо нь илүү, өргөн хүрээг хамарч, тогтвортой байх нь илүү сайн байдаг. Харин иргэний нийгмийн тэргүүлдэг ХОТСЗ хөтөлбөр илүү тохирох ажлыг хийдэг, хүнд хэцүү нөхцөл байдалд ажилладаг, хамт олныг илүү оролцуулсан, өөрийн болгон эзэмших нь илүү байдаг. Засгийн газрын дэмжлэгтэй, соёл, санхүү, хүний нөөц зэрэг орон нутгийн хүчин зүйлийг анхааран үзсэн, орон нутгийн засаг захиргаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага зэрэг гол хүмүүсээс дэмжлэг авсан ХОТСЗ хөтөлбөр илүү амжилттай хэрэгжсэн байдаг.

ХОТСЗ хөтөлбөрийг тогтвортой болгодог зарим нэгэн чухал зүйлүүдийг дурдвал:

- **Үр дүнтэй манлайлал** – Үр дүнтэй манлайлал, менежментгүйгээр ХОТСЗ хөтөлбөр тогтвортой байх нь маш хэцүү. ХОТСЗ хөтөлбөрийн менежерүүд хөтөлбөрийн зорилго, үр дүнд хүрэхийн тулд гол хүмүүсийг урамшуулах, өдөөх, чиглүүлэх, дэмжих үүрэгтэй. Чин эрмэлзэлтэй, харилцааны чадвар сайтай, бусдын хүндлэл хүлээсэн хүчтэй манлайлагч нарыг сонгох нь чухал.
- **Хамтын ажиллагаа** – хэрэв тэд тус тусдаа ажиллавал ХОТСЗ хөтөлбөр хамт олонд дотор бусадтайгаа өрсөлдөж, үйлчилгээг давхардуулж, үнэтэй нөөц бололцоогоо дэмий үрэх эрсдэлтэй. Хамтын ажиллагаа нь байгаа нөөц бололцоогоо зөв зарцуулах, гольдролд оруулж, мэдлэг, чадвар, санхүүгийн нөөцөөр хангах, засгийн газрын хууль тогтоол, бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн талаар дуу хоолойгоо хүргэх зэргээр ХОТСЗ хөтөлбөрийг тогтвортой болгоход тус болно. Ихэнх тохиолдолд үйлчилгээний гэрээ, ойлголцлын меморандум, гэрээ контракт зэрэг албан ёстой үйлдэл хийх нь түншлэгч нарын оролцоог баталгаажуулж, тогтвортой байлгана.
- **Хамт олон өөрийн болгон эзэмших** – амжилттай хэрэгжиж байгаа ХОТСЗ хөтөлбөр нь хамт олны өөрийн болгох үзэл нь илүү хүчтэй байдаг. Менежментийн циклийн бүх шатлалд гол хүмүүсийг оролцуулснаар хүрэх боломжтой (Эрх мэдэлжүүлэх бүрэлдэхүүн хэсэг товхимол: Хамт олныг хөдөлгөх хэсгийг уншина уу)
- **Орон нутгийн нөөц бололцоог ашиглах** – Гадны хүн хүч, санхүү, эд материалаас хамаарах хамаарлыг багасгах нь илүү тогтвортой байхыг баталгаажуулна. Хамт олон өөрийн нөөц бололцоогоо ашиглаж тулгарч байгаа асуудлыг шийдэх хэрэгтэй. Орон нутгийн нөөц бололцоог ашиглахыг тэргүүнд тавьж, үндэсний хэмжээнд гадаад орноос нөөц бололцоог хайхаас илүү үндэсний нөөц бололцоог тэргүүнд тавих хэрэгтэй.
- **Соёлын хүчин зүйлсийг анхааран үзэх** – соёл гэдэг бол харилцан адилгүй байдаг. Хэсэг бүлэг хүнд тохирч байгаа соёл нөгөө бүлэг хүмүүст өөр байж болно. ХОТСЗ хөтөлбөрийг өөр өөр нөхцөл байдалд тогтвортой байлгахын тулд орон нутгийн зан заншил, уламжлалд хэрхэн нөлөөлж байгаа, хөтөлбөрт ямар эсэргүүцэл тулгарч болох, тэр эсэргүүцлийг хэрхэн зохицуулж болох тал дээр анхаарлаа хандуулах нь чухал. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй холбоотой буруу итгэл үнэмшил, зан үйлийг өөрчлөх, хөтөлбөр, үйл ажиллагааг орон нутгийн нөхцөл байдалд тохируулах хоёрын хоорондын тэнцвэрийг нь олох нь чухал.
- **Чадавх бэхжүүлэх** – төлөвлөх, хэрэгжүүлэх, мониторинг хийх, үнэлгээ хийхэд гол хүмүүсийн чадавхыг бэхжүүлснээр ХОТСЗ хөтөлбөр тогтвортой хэрэгжихэд хувь нэмрээ оруулна. ХОТСЗ хөтөлбөр гол хүмүүсийн чадавхыг бэхжүүлэх сургалт зохион байгуулах, ойлголт нэмэгдүүлэх ажил дээр онцгой анхаарал тавих хэрэгтэй. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн чадавхыг бэхжүүлснээр тэд улсаас явуулж буй хөтөлбөр, үйл ажиллагаанд хамрагдах талаараа өөрсдөө нөлөөллийн ажил хийх чадварыг эзэмшинэ.
- **Санхүүгийн дэмжлэг** – бүх ХОТСЗ хөтөлбөрүүд тогтвортой санхүүгийн эх үүсвэртэй байх нь чухал. Санхүүжилтийн төрөл бүрийн сонголтууд байдаг. Тухайлбал, засгийн газрын санхүүжилт (шууд санхүүжилт, буцалтгүй тусламж), хандивлагчийн санхүүжилт (төслийн саналыг үндэсний эсвэл олон

улсын донор байгууллагуудад өгөх, бэлэн бус хандив, эсвэл тэтгэлэг), болон өөрөө олсон орлого (бүтээгдэхүүн зарах, үйлчилгээний төлбөр, эсвэл жижиг санхүүжилт) байна.

- **Улс төрийн дэмжлэг** – ХОТСЗ –ын үндэсний бодлого, үндэсний ХОТСЗ хөтөлбөр, ХОТСЗ сүлжээ болон шаардлагатай төсвийн дэмжлэг нь Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцыг хэрэгжүүлж байгаа бөгөөд хөгжлийн санаачилгууд нь бүх хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд хүрнэ. Засгийн газрын хууль, бодлогод хөгжлийн бэрхшээлийг хамруулснаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа болон нийгмийн салбарт үйлчилгээ авах боломжоор хангагдах юм.

ХОТСЗ хөтөлбөрийг өргөжүүлэх

ХОТСЗ хөтөлбөрийн өргөжүүлэх гэдэг нь амжилттай хэрэгжсэн хөтөлбөрийн үр нөлөөг дэлгэрүүлнэ гэсэн үг юм. Ингэх нь маш олон ач холбогдолтой. Тухайлбал, ХОТСЗ хөтөлбөр хэрэгцээгээ хангаж чадаагүй олон хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүрнэ, нийгэмд хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт нэмэгдэнэ, бодлогод өөрчлөлт хийх дэмжлэг ихэснэ, хөгжлийн бэрхшээлд нөөц бололцоо хуваарилалт нэмэгдэнэ. Өргөжүүлэхэд (i) хөтөлбөр үр дүнтэй байгааг харуулах; (ii) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд хүлээн зөвшөөрдөг байх; (iii) хамт олон хүлээн зөвшөөрдөг байх; (iv) санхүүгийн хангалттай нөөц бололцоотой байх; (v) тодорхой хууль тогтоомж, бодлоготой байх шаардлагатай.

ХОТСЗ хөтөлбөрийг өргөжүүлэх маш олон арга бий. Нэг арга нь хөтөлбөрийн газар зүйн хамрагдалтыг ихэсгэх – ингэснээр хөтөлбөр зөвхөн хэсэг бүлэг хүнд биш олон бүлэг хүмүүсийг хамарч, бүсийн, тэр ч байтугай үндэсний төвшинд хамрагдана. Ихэнхдээ ХОТСЗ хөтөлбөр жижиг газар эхэлж, өргөжихөөсөө өмнө үр дүнгээ харуулдаг. ХОТСЗ олон хөтөлбөрүүд тодорхой хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс дээр анхаарлаа хандуулдаг. Харин өргөжүүлэх бас нэг арга нь төрөл бүрийн бэрхшээлтэй хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулах байдаг.

Менежментийн цикл

ХОТСЗ хөтөлбөрийг боловсронгуй болгох эсвэл бэхжүүлэх талаар бодоход менежментийн процессыг бүхэлд нь харах нь чухал байдаг (Зураг 2). Ингэснээр бүх анхаарч үзэх хэсгийг анхааралдаа авч, хэрхэн нийцэж байгаа, нэгийг нөгөөтэй хэрхэн холбохыг харуулдаг. Энэхүү удирдамжид менежментийн цикл нь дөрвөн үе шаттай байна.

1.Нөхцөл байдлын дүн шинжилгээ – энэ үе нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд амьдарч байгаа хамт олны одоогийн нөхцөл байдлыг судалж, асуудлыг тодорхойлно.



- 2.Төлөвлөлт ба дизайн** – энэ үе нь ХОТСЗ хөтөлбөр асуудлыг хэрхэн шийдвэрлэх, юу хийх талаар төлөвлөнө.
- 3.Хэрэгжилт ба мониторинг** – энэ үед хөтөлбөрийг хэрэгжүүлж, зөв замаар явж байгаа эсэхийг баталгаажуулж тогтмол мониторинг хийнэ.
- 4.Үнэлгээ** – энэ үед хөтөлбөр үр дүндээ хүрсэн эсэхийг үнэлнэ. Хөтөлбөрийн үр дүнд ямар өөрчлөлт гарсан гэх мэт.



I шат. Нөхцөл байдлын дүн шинжилгээ

Танилцуулга

Хамт олны бодит хэрэгцээнд хариу өгөхийн тулд ХОТСЗ хөтөлбөр нь бодит мэдээлэл дээр үндэслэсэн, өртөг хямд, бодит байх нь чухал. ХОТСЗ хөтөлбөрийг эхлүүлэхээс өмнө төлөвлөж байгаа хүмүүс юу хэрэгтэй, юу хийх хэрэгтэй талаар мэдээлэл хангалттай бий эсэхээ болох хэрэгтэй. Ихэнх тохиолдолд энэ мэдээлэл нь бүрэн бус байдаг учраас менежментийн циклийн эхний үе шат нь нөхцөл байдлын дүн шинжилгээ байдаг.



Нөхцөл байдлын дүн шинжилгээ нь “Бид яг одоо хаана байна вэ?” гэсэн асуултад хариулахыг зорьдог. Энэ нь төлөвлөгөө гаргагч нарт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн амьдарч байгаа нөхцөл байдлыг ойлгох, тохирох үйл ажиллагааг тодорхойлоход тусалдаг. Үүнд мэдээлэл цуглуулах, гол хүмүүсийг олж илрүүлэх, тэдэнд нөлөө үзүүлэх, гол асуудлыг тодорхойлж хөтөлбөрийн зорилгыг тодорхойлох, ямар нөөц бололцоо байгааг илрүүлэх зэрэг орно. ХОТСЗ хөтөлбөрийг төлөвлөхөд эдгээр нь хамгийн чухал мэдээлэл байдаг учир энэ нь менежментийн цикл дээрх чухал үе шат юм (2 дугаар шат: Төлөвлөлт ба дизайн-ыг уншина уу).

Шатлалууд

Нөхцөл байдлын дүн шинжилгээнд дараах шатлалууд ордог.

1. Факт, тоо баримтыг цуглуулах
2. Гол хүмүүсийг шинжлэх
3. Асуудлыг шинжлэх
4. Зорилгыг шинжлэх
5. Нөөцийг шинжлэх

Факт, тоо баримтыг цуглуулах

Факт, тоо баримтыг цуглуулах нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаар, тэдний амьдарч байгаа нөхцөл байдлын талаар үнэхээр юу мэдэж байгаагаа олж илрүүлэхэд тусална. Мөн эндээс ирээдүйд үнэлгээ хийхэд тустай суурь мэдээллээ олж авах юм (4 дүгээр шат: Үнэлгээ-г уншина уу). Орчны, нийгмийн, эдийн засгийн, соёлын болон улс төрийн нөхцөл байдлын талаар үндэсний, бүсийн, орон нутгийн төвшинд факт, тоо баримтыг цуглуулж болно.

Тухайлбал, дараах зүйлүүдийн тухай мэдээлэл цуглуулж болно:

- Хүн ам (хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо, нас, хүйс, хөгжлийн бэрхшээлийн хэлбэр гэх мэт);
- Амьдралын нөхцөл (орон байр, ус, эрүүл ахуй гэх мэт);
- Эрүүл мэнд (нас баралтын хувь, шалтгаан, өвчлөл, орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээ гэх мэт);
- Боловсрол (сургуульд сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн тоо, бичиг үсгийн эзлэх хувь гэх мэт);

- Эдийн засаг (орлогын эх үүсвэр, дундаж цалин гэх мэт);
- Засгийн газар (бодлого, хууль журам, хөгжлийн бэрхшээлийг сонирхож байгаа түвшин, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухайн конвенцыг соёрхон баталж, хэрэгжүүлж байгаа байдал, хүртээмжийн стандарт, дүрэм журам гэх мэт);
- Соёл (соёлын бүлгүүд, хэл, хөгжлийн бэрхшээлд хандах хандлага, бодит байдал гэх мэт);
- Шашин (шашны итгэл үнэмшил, шашны бүлгүүд гэх мэт);
- Газар зүй болон цаг агаар.



Фактыг хүмүүстэй ярилцаж (орон нутгийн засаг захиргаан дээр очиж), баримт бичиг үзэж, интернет, засгийн газрын хэвлэл, ном, эрдэм шинжилгээний бичиг баримтаас тоо баримт цуглуулж олж авч болно.

Гол хүмүүсийг шинжлэх

Бүх гол хүмүүсийг олж илрүүлж, хамт олон эзэн нь байх мэдрэмжийг төрүүлэхэд туслах үүднээс тэднийг нь менежментийн циклийн эхнээс нь л оролцуулах нь чухал. Гол хүмүүсийг шинжлэх нь ХОТСЗ хөтөлбөрөөс ашиг хүртэх, хөтөлбөрт хувь нэмрээ оруулах, эсвэл хөтөлбөрт нөлөөлөх гол хүмүүсийг (хувь хүн, бүлэг хүмүүс эсвэл байгууллага) олж илрүүлэхэд тус болно. Гол хүмүүсийг илрүүлэх маш олон арга бий. Тэдний нөлөөллийн төвшинг баримтжуулж, үйл ажиллагааных нь зураглалыг гарга. SWOT шинжилгээ нь гол хүмүүсийн давуу болон сул тал, гадаад боломж болон аюулыг шинжлэхэд хэрэглэдэг нэг арга нь юм.

Гол хүмүүсийн үүрэг, хариуцлага

Гол хүмүүсийг шинжлэх үед маш олон гол хүмүүс олдож болно. Үүнд: хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд, хамт олны гишүүд (манлайлагч, багш гэх мэт), иргэний нийгэм (төрийн бус байгууллага, шашны байгууллага, эмэгтэйчүүдийн бүлэг гэх мэт), хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага болон засгийн газрын эрх бүхий байгууллагууд (Зураг 3) байж болно. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд болон ХОТСЗ хөтөлбөрийн менежерүүд мөн гол хүмүүс. Гол хүмүүс бүр өөрийн ур чадвар, мэдлэг, нөөц бололцоотой байдаг учир ХОТСЗ хөтөлбөрийг боловсронгуй болгох, түүнийг хэрэгжүүлэхэд хүлээх үүрэг, хариуцлагатай байна.

ХОТСЗ-ын гол хүмүүс



Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүл

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд нь ХОТСЗ-нд маш чухал үүргийг гүйцэтгэдэг. Тэдний үүрэг, хариуцлага нь ХОТСЗ хандлагын удирдамжид тодорхой байх бөгөөд үүнийг товчоор дурдвал:

- ХОТСЗ хөтөлбөрийн менежментийн бүх хэсэгт идэвхтэй үүрэг гүйцэтгэх;
- ХОТСЗ хөтөлбөрийн орон нутгийн хороонд оролцох;
- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнаар сайн дураар эсвэл ажиллах;
- Орон нутгийн төвшинд хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт нэмэгдүүлэх (тулгарч байгаа саад бэрхшээлийн талаар асуудал хөндөж, түүнийг арилгах талаар хүсэх гэх мэт).

Хамт олны гишүүд

ХОТСЗ хөтөлбөрөөс зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс биш, хамт олны бүх хүмүүс ашиг хүртэж болно. ХОТСЗ хөтөлбөр нь хамт олны гишүүдийг дараах үүрэг, хариуцлагыг хүлээхийг дэмжиж болно:

- Хөгжлийн бэрхшээлийн талаар илүү мэдээлэл авах зорилгоор сургалтанд хамрагдах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн боломжийг хязгаарлаж байсан өөрийн итгэл үнэмшил, хандлагаа өөрчлөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг хамт олны амьдралд оролцоход нь саад болж буй бүх саад бэрхшээлд анхаарлаа хандуулах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг үйл ажиллагаанд оролцуулах;
- ХОТСЗ хөтөлбөрийн нөөц бололцоонд хувь нэмрээ оруулах (цаг хугацаа, мөнгө, тоног төхөөрөмж);
- Хамт олноо хамгаалж, хөгжлийн бэрхшээлтэй болгож байгаа шалтгааныг анхааралдаа авах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд шаардлагатай үед нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

Иргэний нийгэм

Иргэний нийгмийн байгууллагын, эсвэл бүлгийн үүрэг, хариуцлага нь олон улсын, үндэсний, бүсийн эсвэл хамт олны аль төвшинд байгаагаас шалтгаална. Тэдний үүрэг, хариуцлага нь ХОТСЗ ба хөгжлийн бэрхшээлд хамрагдаж байгаа байдал, оролцооны төвшингээс хамаарна. Түүхээс харахад олон төрийн бус байгууллагууд ХОТСЗ ажлын төвд нь байж, ХОТСЗ хөтөлбөрийн хөдөлгөгч хүч нь болж байдаг. Ерөнхийдөө тэдний үүрэг, хариуцлага нь:

- Засгийн газрын дэмжлэг хязгаарлагдмал үед ХОТСЗ хөтөлбөрийг боловсронгуй болгож хэрэгжүүлэх;
- ХОТСЗ хөтөлбөрт техникийн тусламж үзүүлэх, нөөц бололцоо болох, сургалт зохион байгуулах;
- Гол хүмүүсийн хооронд зуучлах сүлжээг бий болгоход дэмжлэг үзүүлэх;
- Бусад гол хүмүүсийн чадавхыг бэхжүүлэхэд ХОТСЗ хөтөлбөрт туслах;
- Хөгжлийн бэрхшээлийг одоогийн хэрэгжиж байгаа хөтөлбөр, үйлчилгээний гольдролд оруулах;
- ХОТСЗ-ын үнэлгээ, эрдэм шинжилгээний ажил, хөгжилд туслах.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага нь ХОТСЗ хөтөлбөрийг бэхжүүлэхэд чухал нөөц бололцоо нь болдог. Тэд одоо ч ХОТСЗ хөтөлбөрийн үүргийг утга төгөлдөр гүйцэтгэж байгаа (Эрх мэдэлжүүлэх бүрэлдэхүүн хэсэг товхмол: Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллага хэсгийг уншина уу).

Тэдний үүрэг, хариуцлага нь:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн сонирхлыг төлөөлөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээний талаар зөвлөгөө өгөх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өөрсдийнх нь эрхийн талаар боловсрол эзэмшүүлэх;
- Засгийн газар болон үйлчилгээ үзүүлэгч нар тэдний эрхэд (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Конвенцыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэх мэт) хариу үзүүлдэг байхыг баталгаажуулж, лобби болон нөлөөллийн ажил хийх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг үйлчилгээний талаар мэдээллээр хангах;
- ХОТСЗ хөтөлбөрийн менежментэд шууд оролцох.



Засгийн газар

Хөгжлийн бэрхшээлийн асуудлыг засгийн газрын бүх төвшинд, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн зэрэг бүх салбарт анхаарч үзэх ёстой. Тэдний үүрэг, хариуцлага нь:

- Үндэсний ХОТСЗ хөтөлбөрийг хэрэгжүүлэх, манлайлан удирдах;
- Холбогдох хууль дүрэм, бодлогын хүрээг баталгаажуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хөхиүлэн дэмжих;
- ХОТСЗ үндэсний бодлого боловсруулж, холбогдох бодлогод (сэргээн засалт эсвэл хөгжлийн бодлого) ХОТСЗ-ыг стратеги болгон оруулах;
- ХОТСЗ хөтөлбөрийг хүний нөөцийн, эд материалын, мөн санхүүгийн нөөцөөр хангах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг олон нийтийн бүх хөтөлбөр, үйлчилгээ хүртэх боломжтой болгох;
- ХОТСЗ-ыг улс орон даяар сэргээн засалтын үйлчилгээг хүргэх үйлчилгээний механизм эсвэл арга зүй болгон хөгжүүлэх.

ХОТСЗ хөтөлбөрийн менежер

Менежментийн үүрэг, хариуцлага нь ХОТСЗ хөтөлбөрийг хэн санаачилсан, хэн хэрэгжүүлж байгаа, мөн төвлөрлийг сааруулах төвшин, өөрөөр хэлбэл хөтөлбөр үндэсний, бүсийн эсвэл орон нутгийн төвшний алинд хэрэгжиж байгаагаас шалтгаална. Ерөнхийдөө ХОТСЗ хөтөлбөрийн менежерийн үүрэг, хариуцлага дараах байдалтай байна:

- Менежментийн циклийн үе шат тус бүрийг чиглүүлэх;
- Хөтөлбөрийг удирдахад бодлого, тогтолцоо, процедур байгаа эсэхийг баталгаажуулах;
- Хамтын ажиллагаа, сүлжээг бий болгох;
- Бүх гол хүмүүсийг менежментийн циклийн бүх үе шатанд хамруулж, ололт амжилт, хөгжлийн талаар мэдээлэл сайн дамжуулах;
- Санхүүгийн болон хүний нөөц, эд материалын нөөцийг хөдөлгөөнд оруулах, удирдах;
- Хамт олны чадавхыг бэхжүүлэх, хөгжлийн бэрхшээлийг хөгжлийн салбарын гольдрод оруулах;
- Өдөр тутмын үйл ажиллагааг удирдах зохион байгуулах;
- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудыг дэмжиж, хянах (ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд үүрэг, хариуцлагаа мэддэг байх, тэдэнтэй тогтмол уулзаж гүйцэтгэлийг нь болон ахиц дэвшлийг нь үзэж, сургалт зохион байгуулах);
- Ахиц дэвшил, гүйцэтгэлийг хянах мэдээллийн тогтолцоог удирдах.

ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан

ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан нь ХОТСЗ хөтөлбөрийн хамгийн гол хүн байдаг ба хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд болон хамт олны гишүүдийн харилцах чухал хүн байдаг. Тэдний үүрэг, хариуцлага нь ХОТСЗ хандлагын энэхүү удирдамжид маш тодорхой орсон боловч тэд дараах үүрэг, хариуцлагыг биелүүлнэ:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илрүүлж, үндсэн үнэлгээ хийж, энгийн эмчилгээний арга хэмжээ авах;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслах гэр бүлийн гишүүдийг сургах;
- Хамт олон дотор байгаа үйлчилгээнүүдийн талаар мэдээлэл өгөх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг эдгээр үйлчилгээтэй холбох, илгээх, хянах;

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэндийн төв, сургууль, ажлын байртай нь холбоо тогтоож, тэдний хамруулах, хүртээмжийг сайжруулахад нөлөөллийн ажил хийх;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гэр бүл, хамт олны амьдралд оролцуулах талаар дэмжиж хамт олны хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх.

Түвшин	Гол хүмүүс	Үүрэг, хариуцлага
Тосгон	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүд	Гэрээр сэргээн засалт үзүүлэх, гэр орны орчинг тохируулах, нийгэмлэг байгуулах, бусад хүмүүстэй хамтран ажиллах (сайн дурын идэвхтнүүдтэй)
Тосгон	ХОТСЗ хөтөлбөрийн сайн дурын идэвхтэн	Эрт илрүүлэх, илгээх, хянах, тоо баримт цуглуулах, тайлагнах, ойлголт нэмэгдүүлэх, урамшуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүд, хамт олонтой хамтарч нөлөөллийн ажил зохион байгуулах, бусад салбартай холбоо тогтоох
Комун (тосгоны кластер)	Хороо, ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан	Хамтран ажиллаж буй байгууллага, хүмүүсийн үйл ажиллагаанд менежмент хийх, зохицуулах, тайлагнах, нөөцийг хөдөлгөөнд оруулах, хуваарилах, гэрээр сэргээн засалт үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудыг чиглүүлэх
Дүүрэг	Хороо, ХОТСЗ хөтөлбөрийн менежер, нарийн бичгийн дарга, сургагч багш нар, мэргэжилтнүүд	Менежмент хийх, зохицуулах, тайлагнах, нөөц бололцоог хөдөлгөөнд оруулах, хуваарилах, гэрээр сэргээн засалт үзүүлэх, оношлох, үнэлэх, сургалт зохион байгуулах, нөөцийг хуваарилах
Муж (аймаг)	Хороо, ХОТСЗ хөтөлбөрийн менежер, нарийн бичгийн дарга, сургагч багш нар, мэргэжилтнүүд	Бодлого боловсруулах, нөөцийг хуваарилах, институтэд суурилсан сэргээн засалт хийх, ерөнхийд нь удирдах, зохицуулах, мониторинг, үнэлгээ хийх, гэрээр сэргээн засах ажлыг дэмжих, оношлох, үнэлгээ хийх, сургалт зохион байгуулах
Үндэсний	Үндэсний сургагч багш нар, бодлого боловсруулагч нар	Бодлого боловсруулах, материал боловсруулах, институтэд суурилсан үйл ажиллагаа, сургалт, эрдэм шинжилгээний ажил

Асуудлыг шинжлэх

ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн талаарх тухайн хамт олонд байгаа асуудалд анхаарлаа хандуулдаг. Асуудлыг шинжлэх нь асуудлын гол нь юу болох, шалтгаан нь юу болох, үр нөлөө, үр дагавар нь юу болох зэргийг илрүүлэхэд тус болно. Хамгийн гол асуудлыг илрүүлснээр тэр нь ХОТСЗ хөтөлбөрийн гол зорилго болох болно (Хөтөлбөрийн төлөвлөгөөг бэлтгэх хэсгийг уншина уу). ХОТСЗ хандлагын удирдамжийн бүрэлдэхүүн хэсэг, элемент тус бүрд ХОТСЗ хөтөлбөрийн зорилгыг “ХОТСЗ хөтөлбөрийн зорилго” гарчиган дор тодорхойлсон байгаа.

Дээр дурдсан гол хүмүүстэй хамтран асуудлыг шинжлэх хэрэгтэй. Гол хүмүүсийн үзэл бодолгүйгээр асуудалд хандвал асуудлын гол зүйл, хэрэгцээ, шийдвэр тодорхой бус болно. Семинар зохион байгуулах нь гол хүмүүстэй хамтарч асуудлыг шинжлэх, ойлголт, зорилго, үйл ажиллагаагаа хуваалцах сайн

арга болдог хэдий ч ийм уулзалтыг өөр өөр хүмүүстэй олон дахин зохион байгуулж илүү олон эмзэг бүлгийнхэн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломж олгох ёстой.

Асуудлыг шинжлэх маш олон арга байдаг – “асуудлын мод” нь өргөн хэрэглэгддэг, нийтлэг аргуудын нэг нь байж болно. Асуудлын мод нь нөхцөл байдлыг диаграмм хэлбэрт оруулж харах арга юм. Дээд талд нь асуудлаас урган гарах үр дүн, доод талд нь шалтгаануудыг тодорхойлдог.

Зорилгыг шинжлэх

Зорилгыг шинжлэх нь ямар боломжит шийдвэр байгааг тодорхойлохоос эхэлдэг. Зорилгын мод нь энэ дүн шинжилгээг хийх ашигтай арга юм – асуудлын модтой ойролцоо бөгөөд асуудлын оронд зорилгыг хардгаараа онцлог. Хэрэв асуудлын мод ашигласан бол үүнийг зорилгын мод болгон хувиргахад маш амархан. Зорилгын модыг гүйцээхийн тулд асуудлын модон дээр байсан шалтгаанууд (сөрөг)-ыг зорилго болгон тавина (эерэг). Шинжилгээгээр гаргаж ирсэн зорилгууд нь төлөвлөлт ба дизайн үе шатыг тодорхойлоход маш чухал юм. Энэ нь хөтөлбөрийн төлөвлөгөөний үндсийг бий болгож өгдөг. Хөтөлбөрийн циклийн энэ үед олон асуудал, зорилгыг илрүүлдэг учир хөтөлбөр юун дээр нэн тэргүүнд анхаарлаа хандуулах вэ гэдгээ жагсаадаг (Төлөвлөлт ба дизайн хэсгийг уншина уу).

Нөөцийг шинжлэх

Бүх хамт олонд нөөц байдаг, нэн ядууд ч гэсэн байдаг. Нөөцийг шинжлэхийн зорилго нь ХОТСЗ хөтөлбөр хэрэглэж болох нөөцийг хамт олноос илрүүлэхэд оршино. Нөөцийг шинжлэх үед хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээнд зориулах нөөцийн чадавхыг (сул, хүчтэй гэх мэт) илрүүлэх нь чухал. Нөөцийг шинжлэхдээ хүний нөөц, материалын нөөц (дэд бүтэц, барилга байгууламж, тээвэр, тоног төхөөрөмж, санхүүгийн нөөц, одоо хэрэгжиж байгаа нийгмийн тогтолцоо гэх мэт) болон байгууллага, бүлэг, улс төрийн дэд бүтцүүдийг судлах шаардлагатай. Эдгээрийн байршлыг газрын зурагжуулах нь хэрэгтэй байдаг.

II шат. Төлөвлөлт ба дизайн

Танилцуулга

1 дүгээр шат нь ХОТСЗ хандлагыг төлөвлөгч нарт 2 дугаар шат буюу төлөвлөлт ба дизайн хийхэд мэдээллийг өгсөн байх ёстой. Төлөвлөгч нар энэ үе шатанд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нөхцөл байдлын талаар тодорхой дүр зурагтай болсон байх ба ХОТСЗ хөтөлбөр чухам ямар агуулгаар ажиллах нь тодорхой болсон байна. Тэд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тоо, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн хэрэгцээ, асуудлыг шийдэх боломжит шийдвэр, хамт олны нөөц байгаа эсэх талаар мэдээлэлтэй болсон байна.



Төлөвлөлт нь ирээдүйдээ бэлтгэх, түүний талаар бодох, менежментийн циклийн дараагийн шатыг (3 дугаар шат: Хэрэгжилт ба мониторинг) чиглүүлэхэд тусалдаг. ХОТСЗ хөтөлбөрийн анхаарах ёстой зүйл бүрийг анхаарсан эсэхийг баталгаажуулдаг - өөрөөр хэлбэл, нэн тэргүүний хэрэгцээгээ олж илрүүлсэн, зорилгодоо хүрэх тодорхой зураглал (төлөвлөгөө)-тай, мөн ХОТСЗ хөтөлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нөөцтэй байна гэсэн үг.

Шатлалууд

Гол хүмүүстэй хамтарч төлөвлө

Гол хүмүүстэй уулзалт зохион байгуулах нь 1 дүгээр шатанд тодорхойлсон нэн тэргүүний зүйлсүүдийн талаарх ярилцах, хөтөлбөрийн төлөвлөгөөг зохиох, төсвийг бэлтгэхэд сайн арга юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийг төлөвлөх шатанд сайн оролцуулж хэлэлцүүлэгт утга төгөлдөр хамруулах нь чухал. Тухайлбал, мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хөгжлийн бэрхшээлийн хэлбэрт тохируулан хүртээмжтэй форматаар танилцуулах. 1 дүгээр шатанд дурдсанчлан зарим гол хүмүүстэй, тухайлбал хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдтэй уулзалтыг тусгайлан зохион байгуулж, тэдний үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэх боломж олгох хэрэгтэй.

Нэн тэргүүний асуудлыг тодорхойл

1 дүгээр шатанд ХОТСЗ хөтөлбөрийн анхаарч үзэх олон хэрэгцээнүүдийг илрүүлсэн байгаа билээ. Харамсалтай нь нөөц хязгааргүй биш тул нэн тэргүүний зүйлийг сонгож авах хэрэгтэй. Нэр тэргүүний зүйлсийг тодорхойлмогц, нэн тэргүүний хэрэгцээтэй зүйл дээр, өөрчлөх бүрэн боломжтой бол нөөцийг хуваарилах хэрэгтэй. Нэн тэргүүний зүйлсийг сонгох үед тэдгээр нь холбогдолтой, өөрсдийнх нь хэрэгцээнд тохирох зүйл байгаа эсэхийг баталгаажуулахад гол хүмүүсийн оролцоо чухал. Нэн тэргүүний асуудлыг сонгоход бодит байдлыг ойлгох чадвар шаардлагатай – заримдаа гаднын чиглүүлэгч хөтөлбөрийн зорилгоос хазайхгүй байхад тусалдаг.

Хөтөлбөрийн төлөвлөгөөг бэлтгэ

Логик хүрээ нь ХОТСЗ хөтөлбөрийг төлөвлөхөд хэрэглэгдэж болох төлөвлөх арга юм. Логик хүрээ нь хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд бүх зүйлийг анхаарч үзсэн эсэхийг баталгаажуулахад тусалдаг. Дараах асуултуудад хариулахыг зорьдог:

- Хөтөлбөр юунд хүрэхийг зорьж байна вэ? (зорилго, зорилт)
- Хөтөлбөр яаж хүрэхийг зорьж байна вэ? (үр дүн, үйл ажиллагаа)
- Хөтөлбөр амжилтад хүрсэн эсэхийг бид яаж мэдэх вэ? (шалгуур үзүүлэлт)
- Хөтөлбөр амжилтад хүрсэн эсэхийг бид яаж баталгаажуулах вэ? (батлах арга)
- Ямар асуудал гарч болох вэ? (эрсдэл)

Хүснэгт 2: Логик хүрээ

	Товч	Шалгуур үзүүлэлт	Батлах эх үүсвэр	Таамаглал
Зорилго				
Зорилт				
Үр дүн				
Үйл ажиллагаа		Нөөц шаардлагатай	Зардал	

Логик хүрээ ашиглан ХОТСЗ хөтөлбөрийн төлөвлөгөөг бэлтгэхэд дараах шатлалуудыг ойлгох нь чухал. Хүснэгт 2-т логик хүрээний ерөнхий бүтцийг, Хүснэгт 3-т бүрэн бөглөсөн логик хүрээний загварыг харна уу. Логик хүрээнд ашиглагддаг нэр томъёог зарим байгууллагууд өөрөөр нэрлэж болдгийг анхаарна уу.

Зорилгоо тодорхойл

Юу хийхээ (үйл ажиллагаа) бодохоос өмнө хөтөлбөр урт хугацаанд юунд хүрэхийг (зорилго) зорьж байгаагаа сайн ойлгох нь чухал. Зорилго нь ХОТСЗ хөтөлбөрийн хүрэх дээд үр нөлөөг тусгасан байна – Асуудал, хэрэгцээ байхгүй болсон эсвэл нөхцөл байдал маш сайжирсан зэрэг хүсч буй төгсгөлийн үр дүнг тусгасан байна (1 дүгээр шат: Асуудлыг шинжлэх хэсгийг уншина уу)

Зорилтоо тодорхойл

Хөтөлбөрийн зорилт нь зорилгодоо хүрэхийн тулд хөтөлбөр юу хийхийг хүсч байгаагаа тусгана. Хөтөлбөрийн менежментийг амар хялбар болгодог хэдий ч ихэнхдээ нэг зорилт байдаггүй. Зарим ХОТСЗ хөтөлбөр ХОТСЗ хандлагын

матрицийн эрүүл мэнд, боловсрол гэх мэт олон бүрэлхэдхүүн хэсэг/элементийг хамран үйл ажиллагаагаа явуулдаг тул нэгээс илүү зорилтыг дэвшүүлдэг. Ийм тохиолдолд тусдаа логик хүрээ шаардлагатай болно. Харин логик хүрээ нь нэг ерөнхий зорилготой байна (1 дүгээр шат: Асуудлыг шинжлэх хэсгийг уншина уу).

Үр дүнгээ тодорхойл

Үр дүн нь ХОТСЗ хөтөлбөр юунд хүрэхийг хүсч байна вэ гэдгийг тодорхойлдог. Тэд өргөн хүрээтэй, ерөнхий салбарыг хамардаг. Ихэнхдээ логик хүрээ тус бүрд гурваас зургаан үр дүн байдаг (1 дүгээр шат: Зорилгыг шинжлэх хэсгийг уншина уу)

Үйл ажиллагаагаа тодорхойл

Үйл ажиллагаа нь зорилт, үр дүнд хүрэхийн тулд хийгдэх арга хэмжээ, ажил байдаг. Логик хүрээн дээр зөвхөн энгийн, гол үйл ажиллагаануудаа жагсаадаг. Илүү дэлгэрэнгүй үйл ажиллагааг менежментийн цикль дээр дараа нь тухайлбал, ажлын төлөвлөгөөг боловсруулах үед анхаарч үздэг (3 дугаар шат: Дэлгэрэнгүй ажлын төлөвлөгөө боловсруулах хэсгийг уншина уу).

Шалгуур үзүүлэлтээ тодорхойл

Шалтгуур үзүүлэлт нь ХОТСЗ хөтөлбөр үр дүндээ хүрсэн ахиц дэвшлийг харуулахыг зорьдог бөгөөд мониторингод (3 дугаар шат: Хэрэгжилт ба мониторинг хэсгийг уншина уу) болон үнэлгээ хийхэд (4 дүгээр шат: Үнэлгээ хэсгийг уншина уу) чухал байдаг. ХОТСЗ хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт нь дараах зүйлүүдийг хэмжинэ:

- Үйлчилгээний чанар, үйлчилгээг түргэн хүргэж байгаа эсэх;
- Хөтөлбөрийн аль үйл ажиллагаа хүндээ хүрсэн;
- Үйлчилгээний хүртээмж болон бодит ашиглалт;
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарсан зардал;
- Хөтөлбөрийг бодит хэрэгжилт төлөвлөгөөтэйгөө нийцэж байгаа эсэх;
- Хөтөлбөрийн хэрэгжилтийн ерөнхий дэвшил, хөгжил, мөн гарсан саад бэрхшээл.



Шалгуур үзүүлэлт нь SMART байх шаардлагатай:

- **Тодорхой** – шалгуур үзүүлэлтийг бичиж байхдаа та юуг өөрчлөхийг хүсч байгаа нь тодорхой байх ёстой. Тухайлбал, таны өөрчлөхийг хүсч байгаа тоо (хэдэн), чанар (сэтгэл ханамж, сэтгэгдэл, шийдвэр гаргах чадвар эсвэл хандлагыг өөрчлөх) болон өөрчлөлтийг хийх цаг хугацаа (хэзээ, хэр ойрхон гэх мэт);
- **Хэмжиж болохуйц** – шалгуур үзүүлэлтийг бодитоор хэмжих боломжтой юу?
- **Хүрч болохуйц** – Шалгуур үзүүлэлтэд боломжийн өртгөөр хүрч болох уу?
- **Холбогдолтой** – Шалгуур үзүүлэлтүүд хэмжих гэж байгаа зүйлтэйгээ холбогдолтой юу?
- **Цаг хугацаандаа** – шаардлагатай үед шалгуур үзүүлэлтэнд зориулж мэдээлэл цуглуулах боломжтой юу?

Батлах эс үүсвэрээ тодорхойл

Шалгуур үзүүлэлтийг тодорхойлсны дараа шалгуур үзүүлэлт тус бүрийг хэмжих ямар мэдээлэл (батлах эх үүсвэр) хэрэгтэй гэдгээ шийдэх нь чухал. Үүнд тайлан, уулзалтын протокол, оролцогчдын бүртгэл, санхүүгийн тодорхойлолт, засгийн газрын статистик, судалгаа, ярилцлага, сургалтын бичлэг, кейс судалгаа, долоо хоногийн, сарын, улирлын тайлан, хөтөлбөрийн дунд шатны эсвэл эцсийн шатны үнэлгээ гэх мэт орно. Батлах эх үүсвэрээ шийдмэгц хэн, хэзээ, хаана тоо баримтыг цуглуулахыг бодох нь чухал.

Таамаглалаа дэвшүүл

Логик хүрээний таамаглал баганыг бөглөхдөө хөтөлбөр хэрэгжих үед гарч болох эрсдэл, буруу явж магадгүй зүйлсийг анхаарч үзэх хэрэгтэй. ХОТСЗ хөтөлбөр бүрд эрсдэл байдаг: хэдий ч түүнийг эрт илрүүлбэл цаашдын ажилд гэнэтийн гайхашрал гарахгүй үргэлжлэх болно. Эрсдэлийг илрүүлмэгц түүнийг багасгах эсвэл арилгахын тулд хөтөлбөрийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж удирдаж болно. Ингэснээр эрсдэл нь эерэг үр дүн (таамаглал) болж өөрчлөгдөж, логик хүрээнд тусгагдах болно.

Мониторинг, үнэлгээний төлөвлөгөөг бэлтгэ

Хөтөлбөр бүрд мониторинг, үнэлгээний тогтолцоо байдаг. Хөтөлбөр хэрэгжиж эхэлмэгц мэдээлэл цуглуулж эхлэх шаардлагатай байдаг тул эдгээр тогтолцоог төлөвлөх шатандаа анхаарч үзэх нь чухал. Шалгуур үзүүлэлт, батлах эх үүсвэрийг хөтөлбөрийн төлөвлөгөөнд илрүүлмэгц мониторинг, үнэлгээний тогтолцооны үндсэн суурь тавигдаж эхэлнэ (3 дугаар шат: Хэрэгжилт ба мониторинг, 4 дүгээр шат: Үнэлгээ уншина уу).

Ямар нөөц ашиглахаа шийд

ХОТСЗ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нөөц шаардлагатай хэдий ч хөтөлбөр эхлэнгүүт заавал нэн яаралтай байгүй байж болно. Хамгийн гол нь хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нөөц шаардлагатай учир түүнийг хэрхэн олохоо бодож байх нь чухал. 1-р шатанд байгаа нөөцийг олж илрүүлэхийн тулд хийсэн нөөцийн дүн шинжилгээг эргэн санана уу (1 дүгээр шат: Нөөцийг шинжлэх хэсгийг уншина уу). Дараах нөөцүүдийн анхаарч үзэх ёстой.

Хүний нөөц

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц. Тухайлбал, хөтөлбөрийн менежер, ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан, захиргааны туслах ажилтан, жолооч гэх мэт.

Материалын нөөц

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслийн хэлбэр юм. Тухайлбал, албан өрөө, тавилга, компьютер, гар утас, автомашин, дуу дүрс бичлэгийн хэрэгсэл, сэргээн засалтын тоног төхөөрөмж гэх мэт.

Санхүүгийн нөөц

Зардал нь шинэ хөтөлбөр эхлэхэд хамгийн том хязгаарлалт нь болж болно. Тиймээс хэр их мөнгө хэрэгтэйгээ сайтар бодож үзэх шаардлагатай. Үүнийг хийх хамгийн сайн арга бол төсвийг бэлтгэх юм. ХОТСЗ хөтөлбөр одоо байгаа хөрөнгийг эсвэл хандивлагчдын хөрөнгийг ашиглаж байгааг үл шалтгаалан төсвийг бэлтгэх нь үргэлж чухал байдаг.

Төсвийг бэлтгэ

Төсөв нь хөтөлбөрийн төлөвлөгөөгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд, тодорхой хугацаанд зарцуулах мөнгөн дүн юм. Төсөв нь ил тод санхүүгийн менежмент, төлөвлөгөө (хөтөлбөр юунд мөнгө зарах санааг гаргана), хөрөнгө босгох (хандивлагч нарын мөнгө юунд зарцуулагдах талаарх мэдээлэл өгнө), хөтөлбөрийг хэрэгжүүлэх, мониторинг хийх (төсөвлөсөн хөрөнгийг зарцуулалттай харьцуулах), болон үнэлгээ хийхэд чухал юм.

Төсөв нь “Ямар нөөцийг ашиглах вэ” гэдэг хэсэгт дурдсан нөөцийн хүрээнд гарах зардлыг тусгасан байх ёстой. Маш сайн төсөвлөх хэрэгтэй. Хэрэв танд тийм их төсөв байхгүй бол та хөтөлбөрийнхөө зарим үйл ажиллагааг хэрэгжүүлж чадахгүйд хүрнэ. Мөн та зарим нэг зүйлийнхээ төсвийг дэндээ өндөр тавьбал хандивлагч нар хөтөлбөрийг санхүүжүүлэхийг хүсэхгүй байж болно.



	ДҮГНЭЛТ	ТОДОРХОЙЛОГЧ	БАТАЛГААЖУУЛАХ ЭХ ҮҮСВЭР	ТААМАГЛАЛ
ЗОРИЛТ	ХБИ-ийн эрүүл мэнд нь хүрж болох хамгийн сайн чанарт хүрэх	ХБИ-ийн өвчлөл болон нас баралтыг багасгаж Х%	Жишээ нь: орон нутгийн эрүүл мэндийн төвийн статистик	
ЗОРИЛТО	ХБИ нь бусад хүмүүсийн адил эрүүл мэндийн үйлчилгээг тэгш эрхтэйгээр хүртэх	Орон нутгийн эрүүл мэндийн төвд ХБИ-ийн хамрагдах түвшинг нэмэгдүүлэх /Х%, Х жилээр / ХБИ орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээнд сэтгэл хангалуун байх	Жишээ нь: орон нутгийн эрүүл мэндийн төвийн статистик, хөтөлбөрийн дунд ба төгсгөл үед үнэлгээ хийх	Орон нутгийн эрүүл мэнд, халамжийн үйлчилгээ боломжтой байх
ҮР ДҮН	1. ХБИ-ийн эрүүл мэндийн талаарх мэдлэг болон оролцоог сайжруулах 2. Эрүүл мэндийн салбарт хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдээллийг нэмэгдүүлэх 3. Эрүүл мэндийн үйлчилгээг авах саадыг багасгах	Х жилийн хугацаанд Х% ХБИ орон нутгийн өөртөө туслах бүлэгт идэвхитэй хамрагдах Эрүүл мэнд, халамжийн ажилчид хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалтанд жилийн эцсээр хамрагдах Орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээг биеэр хүртэх....	Жишээ: хамрагдахтай тайлан авах Жишээ нь: хамрагдахтай тайлан авах Эрүүл мэндийн үйлчилгээний хяналт, ажиглалт болон хөтөлбөрийн төгсгөл-үнэлгээ хийх	ХБИ эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс гадуур хоцрох Орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээ хангалттай чадамхтай байх
Үйл ажиллагаа	1. Эрүүл мэнд, халамж үйлчилгээний байршлын мэдээллийг өгөх 2. Эрүүл мэндийн тодорхой асуудалд анхаарч, өөртөө туслах бүлгийг байгуулах 3. Орон нутгийн эрүүл мэнд, халамж үйлчилгээний ажилчдийг хөгжлийн бэрхшээлийн талаарх сургалтанд хамруулах 4. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад биеийн саад бэрхшээлийг арилгах арга замыг тодорхойлолтоор хангах	Хэрэгцээт нөөц бололцоо Хүний нөөц - Хөтөлбөрийн менежер 1 - ХОТС3 ажилтан 2 - ХОТС3 сургагч багш 1 Материал - Мэдээллийн бааз - Заах материал - Сургалтын нөхцөл - Хянах механизм - тээвэр	Зардал Хэрэгцээтэй бүх нөөцөд зардлыг хангах	Өгөгдсөн мэдээллийг ХБИ ашиглах ХБИ өөртөө туслах бүлэгт хамрагдах сэдлийг төрүүлэх Эрүүл мэндийн ажилчид сургалтаар авсан мэдээллийг хэрэглэх Эрүүл мэнд яам төсвийг хувиарлах

III шат. Хэрэгжилт ба мониторинг

Танилцуулга

Хэрэгжилт ба мониторинг хэмээх 3 дугаар шат нь 2 дугаар шатны төлөвлөгөөг үйл ажиллагаа болгож, шаардлагатай үр дүнд хүрэхээр төлөвлөсөн бүх шаардлагатай үйл ажиллагааг баталгаажуулдаг. Хэрэгжилтийн шатны үед ХОТСЗ хөтөлбөрийн ахиц дэвшлийг байнга хянах буюу монитор хийх нь чухал. Мониторинг нь менежерүүдэд мэдээлэл өгч, тэд үр дүндээ хүрч, зорилго, зорилтод хүргэхийн тулд богино хугацааны төлөвлөгөөнд өөрчлөлт хийж, шийдвэр гаргана. Мониторингийн тогтолцоог 2 дугаар шатанд төлөвлөсөн байх ёстой бөгөөд шалгуур үзүүлэлт, батлах эх үүсвэрээ тодорхойлсон байна. 3 дугаар шатны үед мониторингийн тогтолцоог хэрэгжүүлэх бөгөөд мэдээлэл цуглуулж, тэмдэглэж, дүн шинжилгээ хийж, ХОТСЗ хөтөлбөрийн менежментэд ашиглах юм.



Авах арга хэмжээ

- Дараах арга хэмжээнүүдийг заавал дэс дараалан хэрэгжүүлэх

Нарийвчилсан ажлын төлөвлөгөө боловсруул

Хэрэгжилтийн шатны эхний хэсэг нь багийн гишүүд болон гол хүмүүсийн тусламжтайгаар хөтөлбөрийг төлөвлөж, нарийвчилсан ажлын төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зүйлийг анхаарч үзнэ.

- Төлөвлөсөн үйл ажиллагаа бүрийг гүйцэтгэхэд юу хийх шаардлагатай вэ
- Түүнийг хэзээ хийж дуусгах ёстой вэ (эхлэх болон дуусах өдөр)
- Түүнийг хэн хариуцах вэ

Ажлын төлөвлөгөөнд бүх мэдээлэл товчоор тусгагдсан байх ёстой. Үүнийг хүснэгтээр хийвэл, эсвэл зургаар илэрхийлбэл харахад хялбар байх болно. Түгээмэл хэрэглэгддэг формат нь Гантын хүснэгт юм.



Нөөцийг хөдөлгөөнд оруулж, удирд

Санхүүгийн нөөц

Хөрөнгө босгох: Шинэ хөтөлбөр боловсруулах болон одоо хэрэгжиж байгаа хөтөлбөрийн ажлыг цааш үргэлжлүүлэхэд санхүүгийн нөөцийг хайх нь чухал. ХОТСЗ хөтөлбөрт зориулж санхүүг өөр олон эх үүсвэрээс хөдөлгөөнд оруулж болно. Боломжтой бол хамт олонд суурилсан санхүүжилт байх хэрэгтэй. Учир нь энэ нь хөтөлбөрийг удаан хугацаанд тогтвортой байлгахад хувь нэмрээ оруулдаг. Хамт олны доторх санхүүгийн боломжит эх үүсвэрүүд нь:

- Орон нутгийн засгийн газрын буцалтгүй тусламж, татаас, тэтгэмж;

- Орон нутгийн бизнесийн хандив, корпорацын тэтгэлэг;
- Иргэний нийгмийн байгууллагууд. Тухайлбал Ротари клуб, Арслан клуб гэх мэт;
- Үйлчилгээний төлбөр, эсвэл шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн төлөө хэрэглэгчийн татвар, хураамж;
- Сугалаа, нийгмийн ажлууд, уралдаан тэмцээн, болон бусад тусгай арга хэмжээнүүд;
- Орлого олох үйл ажиллагаа;
- Жижиг санхүүгийн эсвэл хамт олонд түшиглэсэн эргэлтийн сангууд

Хангалттай нөөц орон нутагт байхгүй бол ХОТСЗ хөтөлбөрийн хэрэгжүүлэхийн тулд хөрөнгө босгох үйл ажиллагаа бүсийн, үндэсний эсвэл олон улсын түвшинд хийх шаардлагатай.

Санхүүгийн менежмент: Санхүүг удирдах ил тод тогтолцоо бий болгох нь чухал. Энэ нь хөтөлбөрийг гол хүмүүст, ялангуяа санхүүжүүлж буй байгууллага, хамт олны гишүүд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хариуцлагатай байгаагаа илэрхийлнэ. Санхүүгийн менежмент нь хөтөлбөрийн менежерийн гол үүрэг бөгөөд хэрэв хөтөлбөр том бөгөөд их мөнгөтэй бол өөр бусад хүмүүс хамрагдаж болно. Санхүүгийн менежментэд дараах зүйлүүд хамрагдана:

- Үйл ажиллагааны зардал төлөвлөсөн үеийнхтэй нийцэж байгаа эсэх, эсвэл хөтөлбөрийн менежертэй тохирсонтой нийцэж байгаа эсэхийг шалгах механизм;
- Санхүүгийн бичилтүүдийг хангалттай хийсэн;
- Санхүүгийн тоог лавлагаанд бэлэн байлгаж шинэчилж байх;
- Тохирох, шалгалт, балансыг тавьсан байх;
- Хөтөлбөрийн санхүүгийн байдлын талаар бүх гол хүмүүст тогтмол мэдээлж байх.

Хүний нөөц

Шинээр ажилд авах: ХОТСЗ хөтөлбөрт менежер, ажилтан шинээр авахдаа боломжтой бол орон нутгаас нь сонгох хэрэгтэй. Учир нь тэд орон нутгийн соёл, хэлийг сайн мэддэг, хамт олны бусад хүмүүстэй илүү сайн ойлголцдог. ХОТСЗ хөтөлбөр мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эсвэл тэдний гэр бүлийн гишүүдийг ажилд авахыг илүү дэмждэг байх ёстой. Учир нь энэ нь ХОТСЗ хандлагын үндсэн зарчим (ХОТСЗ өнөөдөр хэсгийг уншина уу) бөгөөд тэднийг эрх мэдэлжүүлэхэд хувь нэмрээ оруулах юм. Ямар ч тохиолдолд хүмүүсийг ажил гүйцэтгэх тэдний мэдлэг, чадвар дээр үндэслэн ажилд авах ёстой. Ажлын байрны тодорхойлолтыг ажилд авахаасөө өмнө бэлтгэсэн байх ёстой. Үүнд тухайн ажлын үүрэг, хариуцлага, шаардлагатай туршлагын талаар ихэнхдээ бичсэн байдаг.

ХОТСЗ зарим хөтөлбөрүүд, ялангуяа нөөц хязгаарлагдмал үед, сайн дурын идэвхтнүүдийг авдаг. Сайн дурын идэвхтнүүд ажил хийснийхээ төлөө цалин авдаггүй. Харин түүний оронд урамшуулал болон ажлаа гүйцэтгэхэд туслах нөөц авдаг. ХОТСЗ хөтөлбөрт сайн дураараа ажиллах олон хүмүүс байж болно. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, гэр бүлийн гишүүд, оюутан, мэргэжлийн хүмүүс гэх мэт. Сайн дурын идэвхтэн авч ажиллуулахын сайн болон муу талыг аль алиныг нь анхаарч үзэх нь чухал. Тухайлбал, сайн дурын идэвхтнүүд сайн мэдлэгтэй, хямд зардалтай боловч тэдэнд цаг хугацаа бага, солигдолт их байдаг.

Сургалт: ХОТСЗ хөтөлбөрийг менежерүүд, ажилтнууд хүлээсэн үүрэг, хариуцлагаа гүйцэтгэхийн тулд өргөн мэдлэг, чадвартай байх шаардлагатай (1 дүгээр шат: Гол хүмүүсийн шинжилгээ хэсгийг уншина уу). ХОТСЗ хандлагын матриц (Танилцуулга: ХОТСЗ хандлага өнөөдөр хэсгийг уншина уу) болон ХОТСЗ хандлагын удирдамжаар шинэ сургалт хэрэгтэй болж байна. ХОТСЗ хөтөлбөр одоогийнхоо сургалтын хөтөлбөрийг сайжруулах, эсвэл шинээр сургалтын хөтөлбөр боловсруулах шаардлага гарч байж болох юм.

Дэлхий дээр ХОТСЗ хөтөлбөрийн менежер болон ажилтнуудад зориулсан төрөл бүрийн ХОТСЗ-ын сургалтын хөтөлбөр байдаг. Тэдгээрийн агуулга, хугацаа болон явуулж буй байгууллагууд нь бүгд өөр. Тухайлбал, зарим оронд гурав дахь шатлалын институтууд ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудад зориулсан дипломтой курс санал болгож байхад өөр оронд зөвхөн хэдхэн хоногийн эсвэл хэдхэн долоо хоногийн батламжлагдаагүй сургалтыг зохион байгуулдаг.

ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудад зориулсан сургалт нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдэд сайн чанарын үйлчилгээг үзүүлэх чадавхаа сайжруулах зорилготой байдаг. Төрөл бүрийн сэдвээр сургалт явуулах боломжтой. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, хамт олны хөгжил, хамруулсан талаарх практик, харилцаа холбоо, сэргээн засалтын үндсэн чадвар (илрүүлэх, үндсэн скрининг оношилгоо, үнэлэх, үндсэн заслын үйл ажиллагаанууд) болон бүлгийн явц (өөрөө өөртөө туслах бүлэг байгуулах гэх мэт) зэрэг байж болно.

ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудад зориулсан сургалтыг боловсруулахдаа ямар агуулгаар орох талаараа сайтар тунгаах нь чухал. Ихэнхдээ сургалтууд нь хөдөлгөөн засалч, ахуй засалч зэрэг сэргээн засалтын мэргэжилтнүүдэд зориулсан байдаг. Энэ нь хамт олны хөгжилд шаардлагатай чадвар олгохоосоо илүү дээд төвшний клиникийн эсвэл техникийн чадвар олгоход анхаарлаа хандуулдаг учир ихэнхдээ тохиромжгүй, бодит биш байдаг.

ХОТСЗ хөтөлбөрийн менежерүүдэд зориулсан сургалт нь хөтөлбөрийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдах чадавхыг бий болгоход зорьдог. Хөтөлбөрийн менежерүүд хөтөлбөрийн амжилттай хэрэгжүүлдэг энэхүү менежментийн дөрвөн циклийн талаар сайн мэддэг байх нь чухал. Мөн менежерүүд хөгжлийн бэрхшээлтэй талаарх ойлголт болон ХОТСЗ стратегийн талаар ойлголттой байх шаардлагатай.



Жишээ 9 Соломоны арлууд

Илүү дээр тусламж үзүүлэхэд мэргэжлийн боловсролтой байх

2010 онд Соломоны арлуудын Дээд боловсролын коллеж нь ХОТСЗ стратеги дээр суурилсан Хамт олонд түшиглэсэн сэргээн засалтын дипломтой сургалт зохион байгуулав. Үүний зорилго нь ХОТСЗ стратегийг мужийн төвшинд хэрэгжүүлэх мэдлэг, чадварыг эзэмшүүлэхэд оршсон. Хоёр жилийн хугацаанд дараах чадваруудыг эзэмшүүлсэн.

Хүрч үйлчлэх эмчилгээний чадвар – хөгжлийн бэрхшээлийн хэлбэр, хөдөлгөөн засал, ахуй засал, хэл засал гэх мэт гараар хийх ур чадвар.

Хамт олны сэргээн засалтын чадвар – хамт олныг хөгжлийн бэрхшээлийн талаар мэдлэгтэй болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст тэгш боломж олгох гэх мэтээр хамт олонтой ажиллах чадвар.

Хамт олны хөгжлийн чадвар – хамт олон дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг дэмжиж төсөл санаачлах чадвар.

Талбарт дадлага хийх – сурсан мэдсэн зүйлээрээ дадлага хийх.

Сургалтын дараа төгсөгчид ХОТСЗ-ын нэгж (Эрүүл мэндийн болон Эмнэлгийн үйлчилгээний яам) дээр мужид ажиллах эсвэл эмнэлэгт терапевстаар ажиллах мэдлэг, чадвартай болсон байна. Эрүүл мэндийн салбараас гадна боловсролын тогтолцоо болон төрийн бус байгууллага дээр ажиллах боломжтой.

Ажилтнуудыг хөгжүүлэх, дэмжих, хянах:

Ажилтнуудыг хөгжүүлэх (тасралтгүй сургах) нь ХОТСЗ хөтөлбөрийн менежерүүд, болон ажилтнууд өөрсдийнхөө чадварыг шинэчлэх, шаардлагатай бол шинэ чадвар эзэмшихэд чухал юм. Орон нутагт байгаа нөөцийг тасралтгүй сургахад, тухайлбал бусад байгууллагуудаас зохион байгуулдаг, холбогдох салбарын экспертүүдийн явуулж буй сургалтад хамрагдах, сургалтын материал авах зэргээр, ашиглаж болно.

ХОТСЗ зарим хөтөлбөрүүд амжилтгүй байдаг нь тэд өөрсдийнхөө ажилтнуудыг хангалттай дэмжихгүй байгаагаа шалтгаалдаг байж болох юм. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд нь ХОТСЗ хөтөлбөрийг тулгуур багана нь байдаг. Тиймээс менежерүүдийн үгийг сонсдог, тэднийг үүргээ гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлдэг байх ёстой. Өөрөөр хэлбэл тэдэнд хяналтын болон тайлангийн тодорхой чиглэл өгч, үүрэг, хариуцлагаа тодорхой мэдэж байгаа эсэх, мөн гүйцэтгэлийг нь тогтмол үзэж баталгаажуулж дэмжиж туслах ёстой. Хөтөлбөрийн менежерүүдийн ачаалал ихэсч, дэндүү эрчтэй, дэндүү удаан ажиллаж байгаа эсэхийг нь харж байх нь чухал.

Жишээ 10 Папуа Шинэ Гвиней

ХОТС3 хөтөлбөрийн ажилтны найдвартай байдал ба хамт олон дотор эзлэх байр суурь

Папуа Шинэ Гвинейд богино хугацааны сургалт хийсний дараа ХОТС3 хөтөлбөрийн ажилтнууд майга тавхайтай хүүхдийг, катаракттай насан хүрсэн хүнийг скрининг оношилгоонд оруулж, шаардлагатай эмнэлгийн тусламжид ир Лгээх чадвартай болсон. Эдгээр эмчилгээ нь дээрх бэрхшээлтэй хүмүүст болон гэр бүлийн гишүүдэд нь чухал үр дүнтэй бөгөөд энэ нь ХОТС3 хөтөлбөрийн ажилтны найдвартай байдал, түүний хамт олонд дотор эзлэх байр суурийг дээшлүүлж байгаа ажил юм.

Төлөвлөсөн үйл ажиллагаануудыг хэрэгжүүл

Хөтөлбөрийн менежер ажлын төлөвлөгөөг сайн мэдэж, төлөвлөсөн бүх үйл ажиллагаануудыг хийхэд шаардлагатай бэлтгэл ажлыг хангасан байх ёстой. ХОТС3 хөтөлбөрийн үйл ажиллагаануудын нарийвчилсан зүйлийг энд дурдсангүй, энэ талаар бүрэлдэхүүн хэсэг тус бүрд (Товхимол 2-6) болон Нэмэлт товхимолд (Товхимол 7) оруулсан байгаа. Дараах гол үйл ажиллагаануудыг зохион байгуулж болно.

Ойлголт нэмэгдүүлэх

ХОТС3 хөтөлбөрт ойлголт нэмэгдүүлэх үйл ажиллагаануудыг гол хүмүүст хөгжлийн бэрхшээлийн талаарх мэдлэг, мэдээлэл олгох, хандлагын болон зан үйлийн өөрчлөлт хийх зорилгоор чиглүүлэн зохион байгуулдаг. Мөн гол хүмүүсийг ХОТС3 стратеги, хөтөлбөрийг дэмжиж оролцоход нь зориулж зохион байгуулдаг.



Зохицуулах, сүлжээгээр ажиллах

ХОТС3 хөтөлбөрийн гол хүмүүсийн дунд сайн харилцаа холбоо, түншлэл бий болгоход зохицуулах, сүлжээгээр ажиллах шаардлагатай байдаг. Мэдлэг, нөөцөө хуваалцах, давхардалтыг арилгах, хамт олны хүчийг хөдөлгөөнд оруулах гэх мэт олон чухал үйл ажиллагаанууд байдаг.

Гольдролд оруулах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хөгжлийн салбарт (эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, нийгмийн салбар) бүрэн дүүрэн оролцох, түүнээс дэмжлэг авах боломжтой байхыг гольдролд оруулах үйл ажиллагаа гэнэ. Гольдрол оруулах үйл ажиллагаанд тусгайлсан арга хэмжээ дагалдаж байдаг. Тухайлбал, тэгш боломж олгох боломжит тохируулга гэх мэт.

Үйлчилгээ үзүүлэх

ХОТСЗ хөтөлбөр бүр ХОТСЗ-ын матрицаас сонгосон хэсгээсээ шалтгаалан төрөл бүрийн үйлчилгээ үзүүлдэг. ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаануудын ихэнх нь үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг илрүүлэх, нарийн мэргэжлийн үйлчилгээнд илгээх, үндсэн сэргээн засалтын үйлчилгээ үзүүлэх, энгийн туслах хэрэгслээр хангах гээд олон төрлийн үйл ажиллагаа байдаг.

Нөлөөлөл

Түүхийн хувьд ХОТСЗ хөтөлбөр нөлөөллийн ажлыг орхигдуулж, зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үйлчилгээ үзүүлэх дээр анхаарлаа хандуулж байсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрүүл мэнд, боловсрол, амьжиргаа, нийгмийн салбар болон хамт олны амьдралын бусад зүйл дээр эрхээ эдэлж, тэгш боломжоор хангагдахыг баталгаажуулах нөлөөллийн маш олон төрлийн үйл ажиллагаа байдаг.

Чадавх бэхжүүлэх

Гол хүмүүсийн чадавх бэхжүүлснээр тэд үүрэг, хариуцлагаа үүрэх мэдлэг, чадвартай болгоно (1 дүгээр шат: Гол хүмүүсийг шинжлэх уншина уу). Сургалт нь энэхүү Удирдамжид санал болгосон үйл ажиллагаа бөгөөд гол хүмүүсийг чадваржуулах нэг арга нь юм. Гол хүмүүс бүрд нэг ижил төвшний сургалт шаардлагагүй. Сургалтыг тэдний үүрэг, хариуцлага болон түүнээс урган гарах хэрэгцээнд үндэслэх ёстой. Зарим гол хүмүүст ХОТСЗ стратегид чиглүүлэх, хөгжлийн бэрхшээлийн талаар ойлголт өгөх богино хугацааны уулзалт, семинар, ярилцлага шаардлагатай байж болно. Харин заримд нь албан ёсны сургалтын хөтөлбөр шаардлагатай болж болно.

ХОТСЗ хөтөлбөр одоо хэрэгжиж байгаа сургалтын хөтөлбөрүүдийг олж илрүүлэх шаардлагатай. Ийм сургалтын нөөцөд засгийн газрын агентлагууд, хөгжлийн байгууллагууд болон хөгжлийн бэрхшээлээр дагнасан төрийн бус байгууллагууд орж болно. ХОТСЗ сургалтыг хэрхэн зохион байгуулах талаар бусад хүмүүсийг сургах нь бас чухал. Ингэснээр олон хүмүүс ХОТСЗ хандлагын талаар мэдлэгтэй болж, бусдад заах чадварыг эзэмших болно.

Мониторинг

Мониторинг гэж юу вэ?

Мониторинг нь хөтөлбөрийн үйл ажиллагааны жимийг харж хянаж байхыг хэлнэ. Өөрөөр хэлбэр хэрэгжилтийн шатанд мэдээлэл цуглуулж, дүн шинжилгээ хийхийг хэлнэ. Энэ нь аль үйл ажиллагаа сайн явж байна, аль нь сайн биш байна гэдгийг багийн гишүүдэд мэдээлэх хөтөлбөрийн дотоод үйл ажиллагаа юм (ХОТСЗ хөтөлбөрийн менежер, ажилтнуудын хийдэг ажил). Ингэснээр тэд шаардлагатай өөрчлөлтийг хийнэ. Хэрэв мониторингийн тогтолцоо сайн бөгөөд үр дүнтэй бол хөтөлбөрийн үнэлгээг хийх бүр ч хялбархан болно (4 дүгээр шат: Үнэлгээ уншина уу).

Мониторингт хамрагддах шатлалууд

Шалгуур үзүүлэлтийг тогтоох: Шалгуур үзүүлэлтийг 2 дугаар шат: Төлөвлөлт ба дизайн дээр тогтоосон байх ёстой.

Мэдээллээ хэрхэн цуглуулахаа шийдэх: Мониторингийн мэдээллийг хэрхэн цуглуулахаа 2 дугаар шатанд шийдсэн байх ёстой (батлах эх үүсвэр).

Мэдээллээ цуглуулж, бичилт хийх: Мэдээлэл цуглуулах, бичилт хийх албан ёсны тогтолцоотой болох ёстой. Тэрхүү тогтолцоо нь хялбар, зөвхөн хэрэгтэй мэдээллээ цуглуулдаг байх ёстой. Тогтолцоог хэрхэн ашиглах талаар ажилтнуудын сургалтад хамруулах ёстой. Тухайлбал, ажилтнууд мэдээ цуглуулах маягтыг хэрхэн зөв бөглөх талаар сургалтад хамрагдсан байх шаардлагатай. Албан бус тогтолцоо бас байвал ашигтай байж болно. Тухайлбал, ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнуудыг өдрийн тэмдэглэлийн дэвтрээ хадгалахыг хүсч болно. Хөтөлбөрийн тайлангийн хэрэгцээнээс шалтгаалаад мэдээлэл нь өдрийн, долоо хоногийн, эсвэл улирлын байж болно.

Мэдээлэлд дүн шинжилгээ хийх: Мэдээллийг цуглуул, бичилт хийх нь түүнд дүн шинжилгээ хийхээс хялбар байдаг. Гэхдээ ХОТСЗ хөтөлбөрийн менежерүүд тэрхүү мэдээллийг сайтар харахгүй байвал хөтөлбөрийн үйл ажиллагааны ахиц дэвшлийг ажиглахгүй, байгаа асуудлыг илрүүлэхгүй болно. Мэдээлэлд дүн шинжилгээ хийсний дараа үнэхээр юу болоод байгааг олох цаашдын эрэл хайгуул хийх шаардлагатай.

Мэдээллээ тайлагнаж, хуваалцах: Мониторингийн тайланг болон үр дүнг гол хүмүүстэй хуваалцах нь хөтөлбөрт хэр илэн далангүй, хариуцлагатай гэдгээ харуулна. Мониторингийн тайланд үйл ажиллагааг, салбар, тухайн хугацаанд төлөвлөсөн ажил, дуусгавар болсон ажил, хөтөлбөрийн үр дүнд хүрэх ахиц дэвшил, төсөвлөсөн болон зарцуулсан зардлууд, ололт амжилт, саад бэрхшээл/асуудал, хийсэн үйл ажиллагаа эсвэл зөвлөсөн үйл ажиллагаа, эдгээр суралцаж авсан мэдлэг гэх мэт хамрагдана. Тайлангийн шаардлага нь ХОТСЗ хөтөлбөрийн менежментийн бүтцээс шалтгаална. Тухайлбал, орон нутгийн төвшинд ХОТСЗ хөтөлбөрийн ажилтан менежертээ дооо хоногтоо ажлаа тайлагнадаг байхад хөтөлбөрийн менежер дээд төвшний ажилтандаа сар бүр тайлагнадаг гэх мэт.

Мэдээллийг удирдах: ХОТСЗ хөтөлбөрөөс бичиг баримт, тайлан, захидал, бичиг, тооцоо гэх мэт маш их мэдээлэл гардаг. Файл болгон хураах нь мэдээллийг удирдах нэг арга нь бөгөөд мониторингийн үед маш их цаг хугацаа, үл ойлголцлыг хэмнэнэ. Хэрэв нууц мэдээлэл цуглуулсан бол түүнийг аюулгүй газар хадгалах нь зүйтэй.

IV шат. Үнэлгээ

Танилцуулга

Менежментийн циклийн эцсийн шат нь үнэлгээ бөгөөд ХОТСЗ хөтөлбөрийн одоогийн болон дуусгавар болсныг үнэлдэг. Энэ нь хөтөлбөрийн төлөвлөгөөнд дурдсан (2 дугаар шат: Төлөвлөлт ба дизайн хэсгийг уншина уу) үр дүнд хүрсэн эсэх, мөн өмнөх нөхцөл байдал (1 дүгээр шат: Нөхцөл байдлын дүн шинжилгээг уншина уу) өөрчлөгдсөн эсэхийг тодорхойлоход тусална. Үнэлгээгээр хөтөлбөрийг цаашид үргэлжлүүлэх, өөрчлөх, эсвэл зогсоох шийдвэр гаргахад хүргэх ба ХОТСЗ хөтөлбөр нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг тэгш боломжоор хангах, ядуурлыг бууруулах, нийгэмшүүлэхэд сайн стратеги гэдгийг нотлох нотолгоог гаргаж болно.



Үнэлгээ хийлгэхээр тэдний алдаа дутагдал, сул тал ил болно гэж ХОТСЗ хөтөлбөрийн зарим менежерүүд айж, санаа нь зовдог. Ямар ч хөтөлбөр дардан замаар явдаггүй, тэр ч байтугай амжилттай хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдэд ч гэсэн олон асуудлууд тулгардаг гэдгийг ойлгох нь чухал. Амжилттай хэрэгжиж байгаа ХОТСЗ хөтөлбөр тулгарч байгаа асуудлуудад анхаарлаа хандуулж, түүнээс суралцаж, ирээдүйн төлөвлөгөөндөө түүнийг ашигладаг.

Үнэлгээ хэцүү гэж ихэнх хүмүүс боддог. Учир нь гарын авлагууд олон арга, хандлагуудын талаар түвэгтэй ээдрээтэй байдлаар тайлбарладаг. Тиймээс ч ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд үнэлгээ хийхэд эксперт байх шаардлагатай гэж боддог. Гэхдээ төлөвлөлт, бэлтгэ ажлын үеийн зөв түвшинд энгийн үнэлгээ хийж чадвал маш их ашигтай мэдээллийг бий болгох боломжтой.



Үнэлгээ

Үнэлгээ гэж юу вэ?

Хөтөлбөрийн холбогдол, үр ашиг, ашиг тус, үр нөлөө, тогтвортой байдал нь үнэлгээний анхаарах ёстой гол хүчин зүйл байдаг. Үнэлгээ хийснээр ХОТСЗ хөтөлбөр туршлагаасаа суралцаж, одоогийн үйл ажиллагаагаа сурсан зүйл дээрээ тулгуурлаж сайжруулах, ирээдүйд сонголт хийж, илүү сайн төлөвлөдөг.

Үнэлгээг хэн хийдэг вэ?

Үнэлгээг ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд дотооддоо (өөрсдийгөө үнэлэх) хийж болно эсвэл гаднаас бие даасан, хараат бус хувь хүн, байгууллага (гаднаас үнэлэх) хийдэг. Энэ хоёр хандлагад аль алинд нь давуу болон сул тал байдаг. Тиймээс үнэлгээний хандлага хөтөлбөр бүрт харилцан адилгүй байдаг. Төгс хэлбэр нь дээрх хандлагыг хослуулж үнэлгээг хийдэг.

Үнэлгээг хэдийд хийдэг вэ?

Үнэлгээг байнга хийдэггүй учраас мониторингоос өөр байдаг. Үнэлгээг төслийн тодорхой хугацаанд онцгойлсон зүйлийг үнэлэхэд хийдэг. Үнэлгээг хөтөлбөрийн хэрэгжилтийн дунд үед, дууссаны дараа эсвэл хэсэг хугацаа өнгөрсний дараа (нэлээн хэдэн жилийн дараа) хийж болно.

Үнэлгээний шатлалууд

ХОТСЗ хөтөлбөрийн үнэлгээг хэрхэн явуулах нь юуг үнэлэх, хэн үүнийг хүссэн, хэн хийх зэргээс шалтгаална. Ерөнхийдөө дараах шатлалуудыг дамжлаг.

Үнэлгээний фокус

Эхний шатлал нь үнэлгээ юун дээр анхаарлаа хандуулах вэ гэдгээ шийднэ. Өөрөөр хэлбэл үнэлгээг ямар зорилгоор хийх, үнэлгээнээс ямар асуултад хариулт авахаа шийдэх зэрэг хамрагдана.

Нэг үнэлгээгээр хөтөлбөрийн бүх хэсгүүдийг үнэлэх боломжгүй. Тиймээс үнэлгээний зорилгыг сайтар бодох шаардлагатай. Зорилго нь дараах байдалтай байж болно:

- ХОТСЗ хөтөлбөрийн ажилтнууд өөрийн хүлээсэн үүрэг, хариуцлагаа чадвартайгаар гүйцэтгэж байгаа эсэхийг үнэлэх, тэдэнд сургалт шаардлагатай эсэхийг шийдэх;
- Хөтөлбөрийг аль хэсгийг цааш үргэлжлүүлэх, алийг нь цааш үргэлжлүүлэхгүй зогсоохоо шийдвэрлэхийн тулд аль ажил сайн хэрэгжсэнийг үнэлэх;
- Энэ стратегийг цааш давтан үргэлжлүүлэх эсэхээ шийдвэрлэхийн тулд хөтөлбөр төлөвлөсөн үр нөлөөндөө хүрсэн эсэхийг үнэлэх;
- Хөтөлбөрийн ирээдүйг шийдэхийн тулд нөөцийг зөв зарцуулсан эсэх, үр дүндээ хүрсэн эсэх, процедурыг дагасан эсэхийг үнэлэх.

Хүснэгт 4. Үнэлгээний бүрэлдэхүүн хэсгүүд

Холбогдолтой	Хөтөлбөр хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд болон хамт олны хэрэгцээнд нийцсэн үү?
Үр ашиг	Нөөцүүдийг (хүний, санхүүгийн, эд материалын) зөв ашигласан уу?
Ашиг тус	Хөтөлбөр тоон, чанарын, болон цаг хугацааны хувьд үр дүндээ хүрсэн үү?
Үр нөлөө	Ерөнхий зорилгодоо хүрсэн үү? Хөтөлбөр ямар аргаар хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүдийн амьдралыг өөрчилсөн бэ? Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс хүмүүст хандах хандлага болон зан үйлийн хувьд хамт олны төвшинд хөтөлбөр ямар үр нөлөөнд хүрсэн бэ?
Тогтвортой байдал	Хэрэв гаднаас тусламж ирвэл хөтөлбөр үргэлжлэх чадвартай юу?

Мэдээлэл цуглуулах

Хоёр дахь шатлал нь үнэлгээний асуултад хариулах сайн аргыг олж, дараах асуудлуудын талаар бодож үзэх хэрэгтэй.

- **Хэн мэдээлэл өгч чадах вэ** – гол хүмүүс бол мэдээллийн сайн эх үүсвэр байдаг. Мэдээллийг хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, тэдний гэр бүлийн гишүүд, болон хамт олны бусад хөтөлбөрүүд, орон нутгийн засгийн газрын эрх бүхий байгууллагууд (үндэсний статистикийн газар) болон бусад хүмүүсээс цуглуулж болно.
- **Мэдээллийг хэрхэн цуглуулах вэ** – мэдээлэл цуглуулах олон арга бий. Бүгд давуу болон сул талтай. Мэдээлэл цуглуулахад ихэнхдээ нэгээс илүү аргыг хэрэглэдэг (Хүснэгт 5: Тоо баримт цуглуулах арга-ыг уншина уу).
- **Мэдээллийг хэзээ цуглуулах ёстой вэ** – мэдээллийг олон шатлалд цуглуулж болно. Хөтөлбөр эхлэхээс өмнө мэдээлэл цуглуулбал энэ нь суурь тоо (1 дүгээр шат: Нөхцөл байдлын дүн шинжилгээ хэсгийг уншина уу) болно. ХОТСЗ хөтөлбөрийн үр нөлөөг хэмжих гэж байгаа бол суурь тоо маш чухал. Хэрэв хөтөлбөр эхлэхээс өмнөх нөхцөл байдал мэдэгдэхгүй байвал хөтөлбөр ямар нэгэн үр нөлөө гаргасан эсэхийг үнэлэхэд хэцүү болно. Мөн хөтөлбөр хэрэгжиж байх үед мэдээлэл цуглуулж болно (3 дугаар шат: Мониторинг хэсгийг уншина уу). Эсвэл хөтөлбөрийн төгсгөлд мэдээлэл цуглуулж болно.



Хүснэгт 5. Тоо баримт цуглуулах аргууд

Арга	Чанарын	Тоо	Ерөнхий зорилго
Асуумж	Х	Х	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, эцэг эх, болон бусад гол хүмүүсээс сайн тодорхойлсон асуудлын талаар мэдээлэл цуглуулах
Хувь хүнийг үнэлэх	Х	Х	Сайн сайхан байх, эрүүл мэнд, өдөр тутмын үйл ажиллагаа гэх мэт одоогийн нөхцөл байдлыг үнэлэх. Үр дүнг анхны кейс судалгааны тайлантай харьцуулан хэмжинэ.
Судалгаа		Х	Хандлагын өөрчлөлт, амьдралын чанарын өөрчлөлт зэргийг судалгаагаар үнэлэх.
Бичиг баримт үзэх	Х	Х	Хөтөлбөрийн үндэс суурь болж байгаа бодлогыг ойлгож, хөтөлбөр хэрхэн хэрэгжихийг мэдэх (бодлого, дүрэм журам, процедур, захиргааны менежмент зэргийг харах).
Бичлэгүүдийг үзэх		Х	Үйлчлүүлэгчдийн тоо, онцлог чанар, гарсан ахиц дэвшил, авсан арга хэмжээ, орц ба үр дүнгийн хоорондын харилцаа, сэргээн засах ажилтны ажлын ачаалал гэх мэтийг харах.
Ярилцлага	Х		Хэн нэгний үзэл бодол, сэтгэгдэл, эсвэл туршлагыг ойлгох, асуултад хариулсан хариултаас илүү ихийг олж мэдэх.
Ажиглалт	Х	Х	Хөтөлбөр хэрхэн ажилласан, ялангуяа ямар процесс, харилцан үйлчлэл хэрхэн явагдсан талаар бодит мэдээлэл цуглуулах.
Фокус бүлэг	Х		Групп ярилцлага зохиож тодорхой сэдвээр илүү гүнзгий мэдээлэл авах. Тухайлбал асуудлын талаар нийтлэг ойлголтод хүрсэн эсэх, санал, туршлагын талаарх тэдний хариу үйлдлийг мэдэх гэх мэт.

Мэдээлэлд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах

Мэдээлэл цуглуулсны дараа түүнийгээ мэдрэх хэрэгтэй. Мэдээлэлд дүн шинжилгээ хийснээр хэв загвар, хандлага, эсвэл хүлээгээгүй зүйлийг илрүүлж, эсвэл цуглуулсан мэдээлэл үнэлгээний асуултад хариулж байгаа эсэх, тийм бол хэр хэмжээнд хариулж байгааг тодорхойлж болно. Тухайлбал, асуумж, сорил, эсвэл бичлэгээр авсан тоон мэдээллийг ихэнхдээ статистикийн арга, програм ашиглаж шинжилдэг. Ярилцлага, фокус бүлгийн ярилцлагаас авсан чанарын мэдээллийг гол категорид, сэдэвт хуваан зохион байгуулалттайгаар шинжилдэг. Мэдээлэлд дүн шинжилгээ хийсний дараа дүгнэлт гаргаж, хөтөлбөрийн талаар зөвлөмж өгдөг.

Олсон зүйлээ хуваалцаж, үйл ажиллагаа болгох

Хэрэв үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үйл ажиллагаа болгохгүй бол үнэлгээ хийсний ашиг гэж байхгүй. Тиймээс тайлагнаж, олсон зүйлээ хуваалцах нь чухал. Үүнийг хийх маш олон арга байна. Тухайлбал, үнэлгээний тайланг албан

ёсоор бичиж, үнэлгээний үр дүнг хамт олны гишүүдийн уулзалтан дээр танилцуулах, өгүүллэг болгож орон нутгийн сонин хэвлэл дээр нийтлэх, кейс судалгааг сонин хэвлэлээр нийтэлж, бусад байгууллагуудад түгээх, мөн өгүүллэг бичиж сэтгүүл дээр хэвлэх, эсвэл хурал дээр илтгэл болгон тавих гэх мэт. Үнэлгээ хийсний дараа юу нь болоогүй, юу зөв явсан, юуг буруу хийсэн зэрэг хийсэн зүйлээсээ суралцах нь чухал. Юуг үргэлжлүүлэх, юуг өөрчлөх, юуг зогсоох, юу амжилттай хэрэгжсэн, түүнийг хэрхэн өргөжүүлэх, өөр хамт олны ямар тэргүүлэх салбар байгаа гэх мэт үнэлгээний үр дүнг хөтөлбөрийн шийдвэр гаргагч нарт танилцуулах ёстой.

Ашигласан материал

- CBR: A strategy for rehabilitation, equalization of opportunities, poverty reduction and social inclusion of people with disabilities (Joint Position Paper 2004). International Labour Organization, United Nations Educational, Scientific and Cultural Organization, and World Health Organization, 2004 (www.who.int/disabilities/publications/cbr/en/index.html, accessed 30 March 2010).
- Convention on the Rights of Persons with Disabilities. New York, United Nations, 2006 (<http://www.un.org/disabilities/>, accessed 30 March 2010).
- Blackman R. Project cycle management . Teddington, Tearfund, 2003 (<http://tilz.tearfund.org/Publications/ROOTS/Project+cycle+management.htm>, accessed 5 May 2010).
- Australian Agency for International Development. AusGuideline: 3.3: The logical framework approach . Canberra, Commonwealth of Australia, 2005 (<http://www.ausaid.gov.au/ausguide/pdf/ausguideline3.3.pdf>, accessed 5 May 2010).

Цаашид уншихыг зөвлөж буй материал

ARC resource pack: a capacity-building tool for child protection in and after emergencies. London, Action on Rights for Children, 2009 (<http://www.arc-online.org/using/index.html>, accessed 5 May 2010).

Community based initiatives series. Cairo, World Health Organization Regional Office for the Eastern Mediterranean, 2003 (<http://www.emro.who.int/publications/series.asp?RelSub=Community-Based%20Initiatives%20Series>, accessed 5 May 2010).

Community-based rehabilitation and the health care referral services: a guide for programme managers.

Geneva, World Health Organization, 1994 (http://whqlibdoc.who.int/hq/1994/WHO_RHB_94.1.pdf, accessed 5 May 2010).

Cornielje H, Velema JP, Finkenflügel H. Community based rehabilitation programmes: monitoring and evaluation in order to measure results. Leprosy Review, 2008, 79(1):36–49 (<http://www.leprosy-review.org.uk/>, accessed 5 May 2010).

Düring I, ed. Disability in development: experiences in inclusive practices. Lyon, Handicap International, 2006 (http://www.cbm.org/en/general/CBM_EV_EN_general_article_46088.html, accessed 5 May 2010).

FAO Socio-Economic and Gender Analysis Programme. Project cycle management technical guide. Rome, Food and Agriculture Organization of the United Nations, 2001 (<http://www.fao.org/sd/Seaga/downloads/En/projecten.pdf>, accessed 5 May 2010).

Guidance Note 5: Tools for mainstreaming disaster risk reduction – project cycle management. European Commission, 2004 (http://www.proventionconsortium.org/themes/default/pdfs/tools_for_mainstreaming_GN5.pdf, accessed 5 May 2010).

Guidelines for conducting, monitoring and self-assessment of community based rehabilitation programmes:

using evaluation information to improve programmes. Geneva, World Health Organization, 1996 (<http://whqlibdoc.who.int/hq/1996/>

WHO_RHB_96.3.pdf, accessed 5 May 2010).

Handicap International/ Swedish Organisations' of Persons with Disabilities International Aid Association(SHIA)/ Swedish Disability Federation (HSO). A guidance paper for an inclusive local development policy. Make Development Inclusive, 2009 (www.make-development-inclusive.org/toolsen/inclusivedevelopmentweben.pdf, accessed 5 May 2010).

Helander E. Prejudice and dignity: an introduction to community-based rehabilitation, 2nd ed. New York, United Nations Development Programme, 1999 (<http://www.einarhelander.com/books.html>, accessed 5 May 2010).

Make development inclusive: how to include the perspectives of persons with disabilities in the project cycle management guidelines of the EC – concepts and guiding principles. Make Development Inclusive (undated) (<http://www.inclusive-development.org/cbmtools/>, accessed 5 May 2010).

Managing the project cycle. Network Learning, 2009 (http://www.networklearning.org/index.php?option=com_docman&Itemid=52, accessed 5 May 2010).

Manual project cycle management. European Commission Directorate-General for Humanitarian Aid(ECHO), 2005 (http://ec.europa.eu/echo/files/about/actors/fpa/2003/guidelines/project_cycle_mngmt_en.pdf, accessed 5 May 2010).

McGlade B, Mendorza VE, eds. Philippine CBR manual: an inclusive development strategy. Bensheim, CBM/National Council on Disability Affairs (NCDA), 2009.

Ojwang VP, Hartley S. Community based rehabilitation training in Uganda: an overview. (<http://www.asksource.info/cbr-book/cbr04.pdf>, accessed 5 May 2010).

Shapiro J. Monitoring and evaluation. Johannesburg, World Alliance for Citizen Participation (CIVICUS)(undated) (<http://www.civicus.org/new/media/Monitoring%20and%20Evaluation.pdf>, accessed 5 May 2010).

Thomas M. Evaluation of CBR programmes (<http://www.aifo.it/english/resources/online/books/cbr/workshop95/CBR%20evaluation.pdf>, accessed 5 May 2010).

Thomas M, Thomas MJ, eds. Manual for CBR planners . Bangalore, Asia Pacific Disability Rehabilitation


Journal Group, 2003(http://www.aifo.it/english/resources/online/apdrj/Manual%20for%20cbr_planners.pdf, accessed 5 May 2010).

WWF standards of conservation project and programme management . WWF, 2007 (http://www.panda.org/what_we_do/how_we_work/programme_standards/, accessed 5 May 2010).


Zhao T, Kwok J. Evaluating community based rehabilitation: guidelines for accountable practice. Rehabilitation International Regional Secretariat for Asia and the Pacific/ Regional NGO Network for Asia and the Pacific Decade of Disabled Persons 1993 -2002/ Rehabilitation Action Network for Asia and the Pacific Region, 99(<http://www.dinf.ne.jp/doc/english/resource/z00021/z0002101.html#contents>, accessed 5 May 2010).

Хавсралт. ХОТСЗ хөтөлбөрийн менежментийн бүтцийн загварууд


Орон нутгийн түвшин дэх ХОТСЗ хөтөлбөр




Орон нутгийн засгийн эсвэл ТББ-аар хэрэгжих дүүргийн/хороон түвшин дэх ХОТСЗ хөтөлбөр



Улсын болон хувийн түншлэлээр хэрэгжих ХОТСЗ хөтөлбөр



Эрүүл мэндийн яамны ХОТСЗ хөтөлбөр



ХОТСЗ ХАНДЛАГЫН МАТРИЦ

